

**“ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ”-ИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫНТӨСӨЛД
ХИЙСЭН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

УЛААНБААТАР

2023

АГУУЛГА

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	2
НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, СОНГОХ ҮНДЭСЛЭЛ	3
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ	4
2.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	4
2.2.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:	4
2.3.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал	5
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ	8
3.1.“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	8
3.2.“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:	14
3.3.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ	24
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	39
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	45
ХАВСРАЛТ	46

“ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА”-ЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын зорилго нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтад “энэ хуулийн 17, 18 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;” гэж заасны дагуу Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төсөлд тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн бичвэрийг ойлгомжтой, хэрэгжих боломжтой, хүлээн зөвшөөрөгдөх байдлаар боловсруулах болон хуулийн төслийн боловсруулалтын чанарыг сайжруулахад чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөхөд оршино.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төслийн /цаашид “Хуулийн төсөл” гэх/ үр нөлөөг үнэлэх ажиллагааг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын² 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-г баримтлан доорх үе шаттайгаар хийв. Үүнд:

Нэг. Шалгуур үзүүлэлтийг сонгох

Хоёр. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох

Гурав. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж өгөх.

Үр нөлөөний үнэлгээ хийсэн хуулийн төслийн хувилбарыг энэхүү тайланд хавсаргав.

¹ Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2015 оны №25 дугаарт албан ёсоор хэвлэгдсэн.

² Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор батлагдсан.

НЭГ. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, СОНГОХ ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс хуулийн төслийн үр нөлөөг үнэлж, гарах үр дагаврыг урьдчилан тогтоож чадахуйц дараах шалгуур үзүүлэлтийг сонголоо. Үүнд:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Харилцан уялдаа;
- 3.Практикт хэрэглэх боломж зэрэг болно.

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төсөл болон түүний зорилго нь хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан зорилгын хүрээнд боловсруулагдаж чадсан эсэх болон бодит үндэслэл, шаардлагад нийцэж буй байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь төслийн зорилгыг хангахад чиглэсэн бөгөөд түүнд хүргэх боломжтой эсэхийг үнэлнэ.

Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хуулийн төсөлтэй танилцаж хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг судлан үзсэний дагуу хуулийн төслөөс түүний зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн бөгөөд хуулийн зорилгыг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ буюу зохицуулалтыг сонгож авсан болно.

“Зардал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зардлыг “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тусад нь тооцдог тул энэхүү шалгуур үзүүлэлтийн үнэлгээг уг тайлангаас тусдаа бие даасан үнэлгээгээр тооцох болно.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь үнэлэх бөгөөд хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль холбогдох бусад хуультай болон хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо нийцсэн эсэхийг аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр сонгов.

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтууд дагаж мөрдөх болон хэрэгжүүлэхэд боломжтойгоор боловсруулагдаж чадсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага нь хэн байх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг үнэлнэ.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

2.1."Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгахын тулд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг харьцуулан дүгнэхээр зарчмын шинжтэй өөрчлөлтийг үнэлэхээр дараах байдлаар үнэлэх хэсгээ тогтоолоо.

Нэгдүгээр хүснэгт

Хуулийн төслийн зорилгод хүрэх байдлыг сонгон үнэлэх

Зорилгод хүрэх байдал/ дагалдах зорилтууд	Сонгосон зүйл заалт
Гэр бүлийн хуулиар гэрлэлтийн гэрээний зохицуулалтыг тодорхой тусгах	Хуулийн төслийн 3 дугаар бүлэг. 22 дугаар зүйл. Гэрлэлтийн гэрээ байгуулах журам. 23 дугаар зүйл. Гэрлэлтийн гэрээний хэлбэр
Садан төрлийн холбоотой эсэхээ мэдэх боломжийг хангасан зохицуулалт бий болгох	Хуулийн төслийн 5 дугаар зүйл Гэрлэх нөхцөл 5.3. Садан төрлийн холбоотой эсэх лавлагаа авах тухай 5.4. ДНХ-ийн шинжилгээ хийлгэх тухай
Нөхөн үржихүйн арга хэрэгслээр эцэг, эх тогтоох зохицуулалт бий болгох.	Хуулийн төслийн 28 дугаар зүйл. Нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох.
Тэтгэлэгийн хэмжээг тэтгэлэг авагчийн нөхцөл, тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулан шүүх тогтоох зохицуулалт бий болгох	Хуулийн төслийн 49 дүгээр зүйл. Тэтгэлгийн хэмжээ, олгох хугацаа, хэлбэр.
Үрчлэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх	Хуулийн төслийн 65, 67 дугаар зүйл 65 дугаар зүйл. Хүүхэд үрчлэх, үрчлүүлэх зарчим нөхцөл 67 дугаар зүйл. Хүүхэд үрчлэх журам

2.2. "Харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэгдэх хуулийн төслийн зохицуулалт:

Хуулийн төсөл нь өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг "харилцан уялдаа" шалгуур үзүүлэлтийн тусламжтайгаар тогтоох юм. Уг шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зохицуулалтыг үнэлэхдээ тодорхой стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах тул хуулийн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, зохицуулалтыг бус төслийг бүхэлд нь сонгон авч үнэлэх нь зүйтэй тул хуулийн төслийг бүхэлд нь үнэлэхээр сонгосон болно.

2.3. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1/гэрлэх нөхцөлтэй холбоотой заалтууд, 2/гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваахтай холбоотой заалтууд, 3/гэрлэлттэй адилтгах харилцаатай холбоотой заалтууд, 4/эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулахтай холбоотой заалтууд, 5/хүүхдийн тэтгэлэг тогтоолгохтой холбоотой заалтууд, 6/ Хүүхэд үрчлүүлэхтэй холбоотой заалтыг сонгон авч "Практикт хэрэгжих боломж"-ын тооцсон болно. Сонгосон зүйл заалтуудыг дэлгэрэнгүйг хүснэгтээр үзүүлэв.

Хоёрдугаар хүснэгт

Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг сонгон үнэлэх

Д/д	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл заалт
1	Гэрлэх нөхцөл	5.2.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө сайн дураараа, харилцан тохиролцсоны үндсэн дээр эрүүл мэндийн шинжилгээ өгч, эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно. 5.3.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно. 5.4.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно. 5.5.Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхдээ нөгөө талын өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй эсэх мэдээллийг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно.

2	Гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах	14 дүгээр зүйл.Гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах 14.3.Гэрлэгчдийн хэн нэг нь энэ хуулийн 9.4.4-т үүргээ зөрчсөн шалтгаанаар гэрлэлт цуцлах бол гэр бүлийн дундын эд хөрөнгийн өөрт ногдох хэсгийн 25 хүртэлх хувийг нөгөө талдаа шилжүүлнэ. 14.4.Гэрлэгчдийн хэн нэгний нэхэмжлэлээр энэ зүйлийн 14.3-т заасан хөрөнгийн хэмжээг шүүх шийдвэрлэнэ.
3	Гэрлэлттэй адилтгах харилцаа	21 дүгээр зүйл.Гэрлэлттэй адилтгах харилцаа 21.1.Гэрлэлтээ бүртгүүлэгүй боловч, гэр бүлийн хэлбэрийг агуулсан дараах шаардлагыг хангасан 18-н насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүний хамтран амьдарч байгаа дараах харилцааг гэрлэлттэй адилтган үзнэ: 21.1.1.цаашид гэрлэлтээ бүртгүүлэх зорилготой; 21.1.2.хамтран амьдрагчид хоёулаа эсхүл хэн нэг нь өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй байх; 21.1.3.таваас доошгүй жил тогтмол хамтран амьдарсан; 21.1.4.эд хөрөнгө дундаа өмчилж байгаа, хамтын хөрөнгө бий болгосон; 21.1.5.хамтран амьдрагчид нэг оршин суух хаягт бүртгэлтэй; 21.1.6.хамтран амьдрагчид хүүхэдтэй болсон. 21.4.Хамтран амьдрагчдын хамтын амьдрал дуусгавар болох тохиолдолд бие биеэ тэжээн тэтгэх, өв залгаамжлах эрх, үүрэг үүсэхгүй.
4	Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах	43 дугаар зүйл.Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах 43.1.Энэ хуулийн 38, 41 дүгээр зүйлд заасны дагуу эцэг, эх байх эрхийг нь хязгаарласан, хассан тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас уг хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулна. 43.2.Шүүх эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан этгээдийн эрхийг сэргээхдээ зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдсан эсэхийг харгалзана. 43.3.Хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр боловсруулж, зохион байгуулна.

5	Хүүхдийн тэтгэлэг	49.1.Тэтгэлгийн хэмжээ, хугацааг тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулж шүүх аргачлалын дагуу тогтооно. 49.2.Энэ зүйлийн 49.1-д заасан хүүхдийн тэтгэлгийн хэмжээ, хугацаа тогтоох аргачлалыг Засгийн газар тогтооно.
6	Хүүхэд үрчлүүлэх	65.1.Хүүхдийг үрчлэх асуудлыг эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрөл болон энэ хуулийн 67.1-д заасны дагуу Үрчлэлийн зөвлөлийн /цаашид “Зөвлөл” гэх/ дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэнэ. 65.5.Энэ хуулийн 90.1.9-д заасан эрх бүхий байгууллага үрчлүүлэх хүүхэд, үрчлэн авах гэр бүлийн нөхцөл байдалд үнэлгээг хийж Зөвлөлд хүргүүлнэ. 65.6.Нөхцөл байдлын үнэлгээ хийх журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 67.1.Хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үрчлэлийн зөвлөл гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллана. Үрчлэлийн зөвлөлийн ажиллах журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. 67.2.Шүүх Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хүүхдийг үрчлүүлэх эсэх шийдвэрийг гаргана.

ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ

Өмнөх үе шатанд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх хуулийн төслийн зохицуулалтыг тухайн шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийг ашиглан хууль тогтоомжийн үр нөлөөг үнэлэх юм. Шалгуур үзүүлэлтийг дараах шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болно.

Гуравдугаар хүснэгт

д/д	Шалгуур үзүүлэлт	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Зорилгод хүрэх байдлын дүн шинжилгээ хийх: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд дурдсан хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийнэ.
2	Харилцан уялдаа	Харилцан уялдааг шалгах: Хуулийн төслийн уялдаа холбоог аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар шалгана.
3	Практикт хэрэгжих боломж	Практикт хэрэгжих боломжийг шалгах: Хуулийн төслийн практикт хэрэгжих боломжийг аргачлалын 4.6-т заасан асуултад хариулах замаар шалгана.

Дээрх урьдчилан сонгож авсан шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу хуулийн төсөлд үр нөлөөний үнэлгээг дараах байдлаар хийв.

3.1.”Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэхийг шалгах ба хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ шаардлагыг хуулийн төсөлд хэрхэн тусгасныг тогтоох, эдгээр зохицуулалт нь үзэл баримтлалд тодорхойлсон хэрэгцээ, шаардлагад нийцэж байгаа эсэхийг харьцуулан дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн 3 дугаар бүлэг. “Гэрлэлтийн гэрээ”-ны талаарх заалтуудын зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төсөл боловсруулах болсон үндэслэл шаардлага буюу төслийн зорилт нь гэрлэгчдийн болон гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрх ашгийг хамгаалах гэрээний зохицуулалтыг хуульд тодорхой тусгах

явдал байна. Энэ хүрээнд гэрлэгчид хоорондоо ямар нэртэй гэрээ байгуулахыг тодорхой заах, гэрээний нарийвчилсан харилцааг хуулийн төсөлд тусгах талаар үзэл баримтлалд дурджээ. Эдгээр зорилтын дагуу Гэрлэлт цуцлах үед гэрлэгчдийн эд хөрөнгийн эрх ашиг хөндөгдөх, зөрчигдөх нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгажээ.

Иргэний хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т “Гэрлэгчдийн хөрөнгийн эрхийн зарим харилцааг гэрээгээр зохицуулж болно” гэж заасан байдаг. Гэвч өнөөдөр гэрлэгчид эд хөрөнгийн эрхээ зохицуулах боломжтой гэрээ нэрлэгдээгүй гэрээний төрөлд багтаж, чухам ямар гэрээгээр яаж зохицуулах талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна³. Үүнийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 3 дугаар бүлэгт гэрлэгчдийн хооронд байгуулагдах гэрээг Гэрлэлтийн гэрээ гэж нэрлэж, 23 дугаар зүйлийн 23.1-т “Гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлэх, гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт дуусгавар болсны дараа тэдний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, эрх, үүргийг зохицуулах гэрлэлтийн гэрээг гэрлэгчид харилцан тохиролцож байгуулж болно” гэж гэрлэлтийн гэрээг тодорхойлон зохицуулсан байна.

Иргэний хуулийн 132 дугаар зүйлийн 132.5 дахь хэсэгт “Гэрлэгчид гэрээндээ хөрөнгийн бус харилцааг зохицуулсан, гэрлэгчдийн хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илтэд доройтуулсан, эрхийн чадамжийг хязгаарласан нөхцөл тусгахыг хориглоно” гэж заасан байдаг. Гэтэл Хуулийн төслийн 23.1 дэх хэсэгт гэрлэлтийн гэрээгээр эд хөрөнгийн харилцаанаас гадна эд хөрөнгийн бус харилцааг зохицуулахаар заасан нь дээрх Иргэний хуулийн заалттай зөрчилдөж байна.

Эд хөрөнгийн бус харилцаа нь өргөн ойлголт бөгөөд хүүхэддээ овог нэр өгөх, гэр бүлээ төлөвлөх, гэрлэгчид бие биедээ үнэнч байх, халамжлах зэрэг амины эрх үүргийн харилцаа үүнд багтана. Хуулийн төслийн 23.3 дахь хэсэгт гэрлэлтийн гэрээгээр зохицуулахыг хориглосон харилцааг тоочсон байгаа хэдий ч үүнд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явуулах боломжгүй буюу амины харилцааг оруулж өгсөн нь энэ заалтын зорилгод хүрэх байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Хуулийн төсөлд зааснаар гэрлэлтийн гэрээнд эд хөрөнгийн бус амины шинжтэй үүрэг болгосон зохицуулалтуудыг тусгах нь нэг талаас гэрлэгчдийн эд хөрөнгийг зохицуулсан гэрээний мөн чанарыг алдагдуулах, нөгөө талаас эдгээр эд хөрөнгийн бус үүргийг бие биедээ гэрээгээр хүлээлгэж үүргийн гүйцэтгэлийг хангах боломжгүй юм⁴.

Дээрхээс үзвэл, Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 23.1 болон Иргэний хуулийн 132.5 дахь хэсэг хоорондоо зөрчилдөж байх тул аль хуулийг хэрэглэх тухай асуудал үүсэхээр байна. Иргэний хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэж зааснаас харахад Иргэний хуулийн 132 дугаар зүйл зүйл илүү хүчин чадалтай байна.

³ ХЗДХЯ-ны захиалгат судалгаа. “Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”, УБ, 2022 он, 33 дахь тал, болон ХЗҮХ-гийн “Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох тандан судалгаа” УБ, 2022 он, 28 дахь тал

⁴ ХЗДХЯ-ны захиалгат судалгаа. “Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа”, УБ, 2022 он, 17 дахь тал

Тэгэхээр эд хөрөнгийн бус харилцааг зохицуулсан Гэрлэлтийн гэрээг шүүхээс хүчин төгөлдөр бус гэж тооцож хуулийг тайлбарлан хэрэглэх боломжтой. Тиймээс эд хөрөнгийн бус харилцааг гэрлэлтийн гэрээгээр зохицуулах гэсэн хуулийн төслийн зохицуулалт нь гэрлэгчдийн эд хөрөнгийн эрхийг хамгаалах зорилгоос хазайх цаашлаад гэрээнээс үүсэх маргааны тоог өсгөх нөхцөлийг бий болгох эрсдэлтэй. Мөн түүнчлэн Иргэний хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т заасан гэрээ нь Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт зохицуулж байгаа гэрлэлтийн гэрээг зааж байгаа эсэх, аль эсвэл тусдаа гэрээ эсэх нь тодорхой бус, ойлгомжгүй байдлыг бий болгож байна.

Харин гэрээний нарийвчилсан зохицуулалтын хувьд хуулийн төслийн 22, 23 дугаар зүйлд бүлгийн хэмжээнд болон 13, 14 дүгээр зүйлүүд тус тус гэрлэлтийн гэрээтэй холбогдсон заалтуудыг оруулсан байна. Үүнд хуулийн төслийн 22 дугаар зүйлд “Гэрлэлтийн гэрээ байгуулах журам”-ын талаар зохицуулсан байх ба 22.1-т “Гэрлэлтийн гэрээг гэрлэгчид харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр байгуулж, нотариатаар баталгаажуулна”, 22.2-т “Гэрлэлтийн гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрлэлт бүртгүүлсэн эсхүл гэрээ байгуулсан өдрөөс хүчин төгөлдөр болно”, 23 дугаар зүйлд “Гэрлэлтийн гэрээний хэлбэр”-ийн талаар 23.2-т “Гэрлэлтийн гэрээнд дараах зүйлийг тусгаж болно - гэр бүлийн гишүүдийн хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгөнөөс ашиг хүртэх, хуваах; гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгийг тодорхойлох; гэж тус тус нарийвчлан зааж өгсөн байна.

Үүнээс гадна Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Гэрлэлтээ цуцлуулахдаа гэрлэлтийн гэрээг талууд тохиролцсоноосоо өөрөөр шийдвэрлэж болохоор байна”, 14 дүгээр зүйлийн 14.1-т “Шүүх гэрлэлт цуцлахдаа гэрлэлтийн гэрээнд заасны дагуу гэр бүлийн гишүүдийн дундын эд хөрөнгийг хуваана” гэж тусгажээ. Гэрлэгчдийн эд хөрөнгийн талаарх хуулийн зохицуулалт нь Иргэний хуулийн ерөнхий ангид эд юмсын эрх зүйн хэсэгт⁵ зохицуулагдсан байдаг ч үүнийг тусгай хэм хэмжээ буюу гэр бүлийн хуулиар нарийвчлан зохицуулах нь илүү үр дүнтэй байж болох юм. Иймд хуулийн төслийн эдгээр зохицуулалт нь илүү нарийвчилсан зохицуулалтыг агуулсан байх тул гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн эрхийг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх гэсэн төслийн зорилгод хүрэхээр байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3 болон 5.4. “Гэрлэхийг хүсэгчид хоорондоо садан төрлийн холбоотой эсэхээ мэдэх” тухай заалтын зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл шаардлагад хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал тулгамдаж байгаатай холбоотойгоор “гэрлэхийг хүсэгчид хоорондоо садан төрлийн холбоотой эсэхээ мэдэх боломжийг хангах” гэсэн зорилтыг дэвшүүлсэн бөгөөд энэ дагуу хуулийн төслийн үзэл баримтлалд хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр холбогдох зохицуулалтыг тусгахаар заасан байна..

⁵ Иргэний хуулийн 125-133 дугаар зүйл Гэр бүлийн эд хөрөнгийн эрх

Садан төрлийн холбоотой хүмүүс хоорондоо гэрлэж цус ойртсоны улмаас оюуны хомсдолтой, эрүүл бус хүүхэд төрдөг байна. Дэлхийд жишгийг үзвэл, оюуны хомсдолтой хүн 1000 хүн тутамд 10 байх нь хэвийн үзэгдэл гэж үздэг бол Монгол Улсад 1000 хүн тутамд 13 хүн байгаа, хүн амын 6.1 хувь нь цус ойртсон байх магадлалтай бөгөөд энэ тоо жил ирэх тусам өсөж байна⁶. Хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалахад ах дүү, садангаа мэдэхгүй гэрлэх, мэдсээр байж гэрлэх асуудлаас сэргийлэхийн тулд гэрлэх шалгуурт гэрлэгчид хоорондын садан төрлийн холбоогүй эсэхийг нотлох баримтыг гаргаж өгөх зэрэг шалгуур тавьж болох эсэхийг судлах шаардлагатай. Гэрлэгчид хүүхэдтэй болсныхоо дараа гэрлэлтээ бүртгүүлэх тохиолдол нийгэмд цөөнгүй тохиолдох ба энэ үед садан төрлийн холбоотой эсэхээ мэдэх нь ач холбогдол багатай байна.

Дээр дурдсан шалтгаанаар, хуулийн төслийн 5.3-т “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно”, 5.4-т “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно” гэж шинэ зохицуулалт оруулж ирсэн байна. Гэвч хуулийн төсөлд “лавлагаа авч болно”, “шинжилгээ хийлгэж болно” гэж заасан нь сайн дурын үндсэн дээр хэрэгжих арга хэмжээ бөгөөд заавал биелүүлэх шинжийг агуулаагүй тул садан төрлийн холбоотой эсэхээ заавал мэдэх шалгуурыг бий болгоогүй байна. Мөн лавлагаа авах боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд ДНХ-ийн шинжилгээ хийлгэж садан төрлийн холбоотой эсэхээ мэдэх боломжийг хуулийн төсөлд тусгаж өгсөн байна. Энэ нь хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан хүн амын удмын сангийн аюулгүй байдлыг хангах зорилтод нийцэж байгаа ч садан төрлийн холбоотой эсэхээ тогтоох шинжилгээ хийлгэхийг хуулийн төсөлд үүрэгжүүлж өгөөгүй байгаа нь дээрх хуулийн зорилгод бүрэн хүрэх боломжгүй байна.

Хуулийн төслийн 28 дугаар зүйл. “Нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох” заалтын зорилгод хүрэх байдалд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төсөл боловсруулах болсон нэг үндэслэл, шаардлага нь “эцэг, эх тогтоох нь иргэний бүртгэлийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж байгаатай холбоотойгоор тэдгээрийн ажлыг тодорхойлон зааж өгөх”, “нөхөн үржихүйн арга хэрэгсэл ашиглан төрсөн хүүхдийн эцэг, эх тогтоох талаар зохицуулалтыг шинээр оруулах” гэсэн зорилт байх бөгөөд энэхүү зорилтын хүрээнд иргэний бүртгэлийн үйл ажиллагаа илүү ойлгомжтой, эцэг, эх тогтоолгох асуудлыг тодорхой болгох оновчтой зохицуулалтыг тусгах замаар хуулийн төслийг боловсруулна гэжээ.

Сүүлийн 5 жилийн дунджаар шүүхээр эцэг, эх тогтоох тухай хэрэг жилд 411 байгаа⁷ бөгөөд хэрэв шүүхэд захиргааны журмаар эцэг, эх тогтоох харилцааг нэмж өгвөл шүүхийн ажлын ачаалалд энэ хэмжээгээр дарамт болно. Нөгөөтэйгүүр нөхөн

⁶ ХЗҮХ-гийн “Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох тандан судалгаа” УБ, 2022 он, 23 дахь тал

⁷ Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төслийн үзэл баримтлал, 2022 он, 3 дахь тал

үржихүйн аргаар хүүхэдтэй болох шинэ харилцааг бий болгосноор эцэг, эх тогтоох тухай шинэ төрлийн хэрэг маргаан ч гарч болохыг үгүйсгэхгүй.

Манай улсын хууль тогтоомжид нөхөн үржихүйн аргаар хүүхэдтэй болох тохиолдлууд цөөнгүй. Тухайлбал тээгч эхээр хүүхэд төрүүлэх, донорын аргаар эс шилжүүлэн суулгах байдлаар үр тогтоох тохиолдлууд байна. Гэвч энэ төрлийн харилцааг зохицуулсан хууль эрх зүйн орчин, зохицуулалт хангалттай биш. Үүнээс болж шүүх дээр тээгч эхийг хүүхдийн эхээр тогтоох эсэх, аль эсхүл тээгч эхтэй гэрээ байгуулсан талыг эцэг, эхээр тогтоох уу гэдэг маргаан гарч хүүхдийн эрх ашиг зөрчигдөх нөхцөл бүрэлдэх эрсдэлтэй байна.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлд нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох тухай хуулийн зохицуулалтыг шинээр оруулж өгсөн. Хуулийн төслийн 28 дугаар зүйлийн 28.1-т “гэрлэгчид нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болохоор үр хөврөлийн донор, эсхүл тээгч эмэгтэйтэй гэрээ байгуулсны үндсэн дээр төрсөн хүүхдийн эцэг, эх байна”, 28.3-т “Нөхөн үржихүйн туслах аргыг ашиглах гэрээ байгуулсан гэрлэгчид үр хөврөлийн донорыг эцэг /эх/-ээр тогтоолгох нэхэмжлэл гаргах эрхгүй, мөн 28.4-т “...донор, эсхүл тээгч эмэгтэй өөрийгөө эцэг, эхээр тогтоолгох нэхэмжлэл гаргах эрхгүй” гэж зааж өгсөн байна. Үүний үр дүнд шүүх дээр нөхөн үржихүйн арга ашиглаж төрсөн хүүхдийн эцэг, эх тогтоох тухай маргаан үүсэхгүй гэсэн үг юм.

Иймд эдгээр зохицуулалтууд нь хуулийн төсөл боловсруулах үндэслэлийн нэг болсон иргэний бүртгэлийн байгууллагын ажлыг тодорхой болгох, нөхөн үржихүйн аргыг хэрэглэж төрсөн хүүхдийн эцэг, эх тогтоох тухай зохицуулалтыг тодорхой болгосон тул хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой байна.

Хуулийн төслийн 49 дүгээр зүйл. “Тэтгэлгийн хэмжээ, олгох хугацаа, хэлбэр” заалтын зорилгод хүрэх байдлын хүрээнд хийсэн дүн шинжилгээ

Хуулийн төсөл боловсруулах болсон нэг үндэслэл шаардлага нь хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг авагчийн нөхцөл, тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулан шүүх тогтоох гэсэн зорилт байх бөгөөд энэхүү зорилтын дагуу хуулийн төслийн үзэл баримтлалд хүүхдийн тэтгэлгийг төлөгддөг болгох түүний хэмжээг ихэсгэх чиглэлээр хуулийн төсөл боловсруулна гэж заасан байна.

Одоо мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд “хүүхдийн тэтгэлгийг сард нэг удаа 1-11 хүртэлх насны хүүхдэд амжиргааны доод түвшин⁸-гийн 50 хувиар, 11-16 хүртлэх насны хүүхдэд амьжиргааний түвшингийн доод хэмжээгээр” тус тус тогтооно гэж заасныг Хуулийн төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 “Тэтгэлгийн хэмжээ, хугацааг тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулан шүүх аргачлалын дагуу тогтооно” гэж оруулсан нь төлбөрийн хэмжээг ихэсгэх гэсэн хуулийн зорилгод хүрэх боломжтой боловч нөгөө талаар одоо мөрдөгдөж байгаа хэмжээг багасгах эрсдэлтэй

⁸ Хүн амын амьжиргааны 2023 оны доод түвшинг тогтоох тухай Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны Даргын 2023 оны 01-р сарын 23-ны өдрийн А/23 дугаар тушаал, Улаанбаатар хот – 313400 төгрөг

зохицуулалт байна. Төлбөр төлөгч нь ямар ч орлогогүй эсхүл орлого тасалдсан зэрэг тохиолдлуудад тэтгэлэг төлөгчийн орлогыг зөв тодорхойлоход хүндрэл бэрхшээл үүсэх, тэтгэлэг төлөлтийг тасалдуулах, цаашлаад орлого олохгүй бол тэтгэлэг төлөгдөхгүй байх нөхцөл бололцоог бүрдүүлж байна. Шүүхээс тэтгэлэг төлөгчийн орлогыг зөвхөн бичиг баримт дээр тулгуурлах буюу нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байдал зэргийг харгалзан бодитойгоор тогтоох боломжтой талаар шүүгчтэй хийсэн ярилцлагын судалгаанд дурдаж байв.

Харин нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар төлдөггүй тохиолдолд хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн ямар орлоготой нь уялдуулж тогтоох нь ойлгомжгүй байна. Банкин дахь дансны хуулганд гүйлгээ хийгдээгүй эсхүл тэтгэлэг төлөгчийн өөрийнх нь мөнгө эсэхийг тодорхойлоход хүндрэл бэрхшээл үүсч болохоор байна. Иймд шүүхээс тэтгэлэг төлөгчийн орлогыг үнэн, зөвөөр тодорхойлоход ихээхэн хүндрэл үүсэхээр байгаа бөгөөд шүүхээс үүнтэй холбоотой ажиллагаа хийхэд их хугацаа зарцуулахаар байгаа нь хүүхдийн эрх, ашиг зөрчигдөх эрсдэлийг үүсгэнэ⁹. Улмаар дээрх хуулийн төслийн зохицуулалт нь хүүхдийн тэтгэлэг төлөгддөг болгох, тэтгэлгийн хэмжээг ихэсгэх гэсэн хуулийн зорилгод хүрэх боломжгүй байна.

Хуулийн төслийн 65, 67 дугаар зүйл. “Хүүхэд үрчлэх” тухай заалтын зорилгод хүрэх байдлын хүрээнд хийсэн дүн шинжилгээ

Гэр бүлийн тухай хуулийн төсөл боловсруулах болсон нэг үндэслэл шаардлага нь Үрчлэх асуудлыг шийдвэрлэхэд хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах гэсэн зорилт бөгөөд энэхүү зорилтын дагуу хуулийн төслийн үзэл баримтлалд үрчлэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхээр Хуулийн төслийг боловсруулна гэжээ.

2017 оноос 2022 оны 3 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 7596 хүүхэд дотоодод үрчлүүлсэн¹⁰ бол Монгол Улсын харьяат нийт 274 хүүхэд 1999 оноос 2022 он хүртэлх хугацаанд гадаадын иргэдэд үрчлэгдсэн¹¹ байна. Хүүхэд үрчилснийг хүчингүйд тооцсон 2018-2021 оны шүүхийн шийдвэрүүдийн дийлэнх нь Гэр бүлийн тухай хуулийн 61.2-т заасан “бусад үндэслэл”-ээр үрчлэлтийг хүчингүйд тооцсон байна. Үүнд, гадаад улсад ажиллаж сурч ирээд хүүхдээ өөр дээрээ буцааж авах болсон, эцэг, эх нь хүүхдээ өөрийн асрамжид авах болсон, үрчлэгч өндөр насанд хүрсэн, эсвэл нас барсан зэрэг шалтгаан багтаж байна. Гэр бүлийн тухай хуульд заасан үрчлэлтийг хүчингүйд тооцох “бусад үндэслэл”-д буюу одоогийн практикт үүсч буй асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар шалтгаанаар хүүхдийг үрчилж, үрчлүүлж байгаа, тухайн шалтгаан нь хэр бодитой эсэхийг тогтоохын тулд хүүхэд үрчлэлтийн асуудлыг шүүх шийддэг байх нь ач холбогдолтой байна. Шүүхийн статистик тооноос үзвэл үрчлэлтийг хүчингүйд тооцсон

⁹ Шүүгчтэй ярилцсан ганцаарчилсан ярилцлагын үр дүнд шүүгч “төлбөр төлөгчийн орлогыг тодорхойлох нь шүүхэд ачаалал үүсгэх төдийгүй тухайн этгээдийн орлогыг үнэн зөв тодорхойлох боломжгүй” гэсэн санал, зөвлөмж өгсөн.

¹⁰ Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төслийн үзэл баримтлал, 2022 он, 3 дахь тал

¹¹ Гадаадын иргэн, харьяатын газар 2021-2022 оны тайлан 15 дахь тал

хэрэг маргаан сүүлийн 3 жилийн дунджаар жилд 2000¹² гаруй байна. Энэ нь хүүхэд үрчлэх асуудал үр дүнгүй, хүүхдийн эрх ашиг зөрчигдөж байна гэдгийг харуулж байна.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гэр бүлийн тухай хуулийн 55.7-д “Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана”, 58.1-д “Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргана¹³” гэж тус тус заасныг Хуулийн төслийн 67 дугаар зүйлийн 67.1-т “Хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үрчлэлийн зөвлөл гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллана”, мөн 67.2 дахь хэсэгт “Шүүх Зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн хүүхдийг үрчлүүлэх эсэх шийдвэрийг гаргана” гэж зохицуулсан байна. Үрчлэх эсэх талаар дүгнэлтийг одоо үйлчилж байгаа хуульд сум, дүүргийн Засаг дарга хянан үздэг байсан бол хуулийн төсөлд гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Үрчлэлтийн зөвлөл хариуцахаар заасан нь гэр бүл, хүүхдийн чиглэлээр дагнан ажилладаг, илүү мэргэшсэн субъект буюу хамтарсан баг ажиллаж дүгнэлт хийхээр тусгасан нь хүүхдийн эрх, ашиг хөндөгдөх тохиолдолыг бууруулах боломжтой байж болох юм. Мөн түүнчлэн тус Үрчлэлтийн зөвлөлийн дүгнэлтийг шүүхээс үнэлж, үрчлэх эсэх тухай шийдвэрийг гаргаж байгаа нь үрчлэх хүсэлт гаргаж буй этгээдийг илүү хариуцлагатай хандахад нөлөөлөхөөр байна.

Монгол Улсын харьяат хүүхдийг гадаад улсын иргэнд үрчлүүлэхдээ хуулийн төслийн 83 дугаар зүйлийн 83.6 дахь хэсэгт “Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын гэр бүл, иргэнд үрчлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Гадаад Үрчлэлтийн зөвлөл ажиллана”, 83.7 дахь хэсэгт “Үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ” гэж тус тус заасан байна. Дээр дурдсан үрчлэх хүсэлт гаргаж байгаа Монгол Улсын иргэнтэй адилаар гадаадын иргэний хүсэлтэнд Гадаад үрчлэлтийн зөвлөл дүгнэлт гаргаж шүүх үрчлэх эсэхийг шийдвэрлэхээр тус тус зохицуулсан байна. Эндээс үзвэл, мэргэшсэн зөвлөл ажиллаж дүгнэлт гаргасныг шүүхээс эцэслэн шийдвэрлэдэг болсноор хүүхдийн эрхийг хамгаалах зорилгодоо хүрэх боломжтой гэж үзэж байна.

3.2. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах асуултад хариулах замаар хуулийн төслийг бүхэлд нь үнэлж, хуулийн төслийн зохицуулалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хуульд нийцэж байгаа эсэхийг шалгах байдлаар уялдаа холбоог тогтоохыг зорьлоо.

1.Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;

¹² Улсын бүртгэлийн ерөнхийн газраас авсан 2020-2022 оны 3 жилийн статистик тоон үзүүлэлт“

¹³“Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх журам”-ын 5 дугаар зүйл Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны болон байнга оршин суугаа газрынхаа үрчлэлтийн асуудал эрхэлсэн байгууллагаар уламжлан Монгол Улсын Хүн амын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

Гэр бүлийн тухай хуулийн зорилт нь төсөлд зааснаар “гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхэд үрчлэх харилцааг зохицуулахад” оршиж байгаа бөгөөд хуулийн төслийн зохицуулалт нь дээрх зорилттой нийцэж байна.

2.Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;

Төслийн 2.1-д “Гэр бүлийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ” гэж заажээ. Гэр бүлийн тухай хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хуулийн дараа орох суурь харилцааг зохицуулж буй хувийн эрх зүйн хууль тул бусад хууль тогтоомж нь дээрх 3 хуульд нийцсэн байхаар тусгасан нь зохистой байна. Уг заалтад нэр заасан хоёр хууль нь тухайн харилцаанд хамаарах хууль мөн байна.

3.Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;

Одоо мөрдөж буй Гэр бүлийн тухай хуульд заасан 8 нэр томъёоны тодорхойлолт дээр 5-ыг нэмж, хуулийн төсөлд нийт 13 нэр томъёоны тодорхойлолт хийжээ. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.1.3.3-т шинээр бий болсон ойлголт буюу тухайн нэр томъёо нийтэд ойлгомжгүй бол нэр томъёоны тодорхойлолт хийхээр заасан байх тул “Гэрлэлтийн гэрээ” гэсэн шинэ ойлголтын нэр томъёоны тодорхойлолтыг хийх нь зүйтэй. Мөн төслийн үр нөлөөний судалгааны хүрээнд тус хуулийг хэрэгжүүлэх субъектээс санал авах явцад “үнэнч байх үүрэг” гэсэн ойлголтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэсэн саналыг ирүүлж байв.

4.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;

4.1.Хуулийн төсөл дэх гэрээний төрөл, хэлбэрийг зохицуулсан зохицуулалтын хоорондын уялдаа холбоо

Энэ хэсэгт хуулийн төсөлд туссан гэрээний зохицуулалтын хоорондын уялдаа, нийцлийг авч үзлээ. Хуулийн төсөлд дараах 6 төрлийн гэрээ байгуулахаар заажээ. Үүнд:

- 1.Гэрлэлтийн гэрээ,
- 2.Тэжээн тэтгэх гэрээ,
- 3.Нөхөн үржихүйн туслах аргыг ашиглах гэрээ,
- 4.Эцэг эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ,
- 5.Асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээ,
- 6.Үрчлэгчтэй байгуулах гэрээ

Дөрөвдүгээр хүснэгт

Гэр бүлийн хууль дахь гэрээтэй холбоотой зохицуулалт

Гэрээний нэр	Хуулийн зохицуулалт
Гэрлэлтийн гэрээ	23 дугаар зүйл.Гэрлэлтийн гэрээний хэлбэр 23.1.Гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлэх, гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт дуусгавар болсны дараа тэдний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, эрх, үүргийг зохицуулах гэрлэлтийн гэрээг гэрлэгчид харилцан тохиролцож байгуулж болно.
Нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болох гэрээ	28 дугаар зүйл.Нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох 28.1.Гэрлэгчид нөхөн үржихүйн туслах аргыг ашиглаж хүүхэдтэй болохоор үр хөврөлийн донор, эсхүл тээгч эмэгтэйтэй гэрээ байгуулсны үндсэн дээр төрсөн хүүхдийн эцэг, эх байна.
Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ	34.3.Хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшлахааргүй бол гэрлэлтээ цуцлуулсан, гэрлэлтээ бүртгүүлээгүй хамтран амьдарч байсан эцэг, эх тусдаа амьдарч байгаа бол эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ байгуулж болно. 34.4.Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх тухай гэрээгээр хүүхэдтэй хамт амьдрах эцэг, эсхүл эх, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн <u>хүүхдүүдтэйгээ харилцах, тэднийг хүмүүжүүлэхэд хүлээх үүрэг, олгох тэтгэлгийн хэмжээг тохиролцож</u> болно.
Тэжээн тэтгэх тухай гэрээ	51 дүгээр зүйл.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах, хүчингүйд тооцох 51.1.Тэтгэлэг төлөгч болон тэтгэлэг авагч нь <u>тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг төлөх нөхцөл, журмыг харилцан тохиролцож, тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулж болно.</u> 51.2.Тэжээн тэтгэх тухай гэрээ байгуулах, өөрчлөх, цуцлах хүчингүйд тооцох асуудлыг Иргэний хуульд заасан гэрээнд тавигдах үндэслэл, журмын дагуу шийдвэрлэнэ. 46 дугаар зүйл.Гэрлэгчдийн бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүрэг 46.1.Гэрлэгчид бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүргээ хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулж болно.

Асран хүмүүжүүлэх тухай гэрээ	62 дугаар зүйл.Хүүхдийг гэр бүлдээ авч асран хүмүүжүүлэх үйл ажиллагаа 62.1.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг иргэн гэр бүлдээ авч асран хүмүүжүүлж /цаашид “асран хүмүүжүүлэх (асралт гэр бүл) гэр бүл” гэх/ болно. 62.2.Хүүхдийг асран хүмүүжүүлэхдээ гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болон асран хүмүүжүүлэхээр хүсэлт гаргасан иргэний хооронд хугацаатай гэрээ байгуулна. 62.4.Хүүхэд асран хүмүүжүүлэх тухай гэрээнд хүүхдийг асрах, хүмүүжүүлэх, боловсрол олгох нөхцөл, асран хүмүүжүүлэгчийн болон гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын эрх, үүрэг, асран хүмүүжүүлэгчид олгох урамшуулал, хууль тогтоомжийн дагуу олгогдох бусад хөнгөлөлт, гэрээ дуусгавар болох хугацаа, үндэслэл, үр дагаврыг заана.
Үрчлэгчтэй байгуулах гэрээ	84 дүгээр зүйл.Гадаад улсад үрчлэгдсэн хүүхдэд хяналт тавих 84.3.Харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага тухайн үрчлэгч гэр бүлтэй, эсхүл энэ хуулийн 83.5-д заасан итгэмжлэгдсэн байгууллагатай гэрээ байгуулна. 84.4.Энэ зүйлийн 84.3-т заасан гэрээнд талуудын эрх, үүрэг, хариуцлага, хүүхдэд эх орныг нь таниулах, хүүхдийн нөхцөл байдалтай танилцах, түүний хэрэгжилтийн тайлан хүргүүлэх хугацааг тохиролцож байгуулна. 84.6.Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэгч талд үрчлүүлсний дараа хяналт тавих, үрчлэгч талтай гэрээ байгуулах журмыг хууль зүйн, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ, тэжээн тэтгэх гэрээний зохицуулалтын үйлдээ

Хуулийн төслийн 34 дүгээр зүйлд эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ, 51 дүгээр зүйлд тэжээн тэтгэх гэрээний зохицуулалтыг тусгажээ. Дээрх хоёр гэрээ нь гэрээ байгуулах субъект, гэрээний агуулга, зорилтоороо ялгаатай боловч хүүхдийн тэтгэлгийн хэмжээг эцэг, эх хоорондоо тохирох асуудлыг зохицуулж буйгаараа нийтлэг байна. Тухайлбал, Эцэг, эхийн эрх хэрэгжүүлэх гэрээнд “тусдаа байгаа эцэг, эх хүүхдэдээ олгох тэтгэлгийн хэмжээг тохиролцох”, харин Тэжээн тэтгэх гэрээнд “Тэтгэлэг төлөгч болон тэтгэлэг авагч нь тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг төлөх нөхцөл, журмыг харилцан тохиролцох” зэргээр заажээ.

Дээрхээс харахад эдгээр гэрээний зохицуулалт практикт зарим тохиолдолд хэрэглээний хувьд давхцах нөхцөл үүсэх эрсдэлтэй байна. Тухайлбал, гэрлэлтээ цуцлуулсан гэрлэгчдийн хэн нэг нь хүүхдээ тэжээн тэтгэх гэрээ байгуулж, тэтгэлгийн хэмжээг нарийвчлан зохицуулах боломжтой байна. Харин тэжээн тэтгэх гэрээ байгуулаагүй боловч хүүхэдтэйгээ уулзах зэрэг харилцааг зохицуулсан эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээнд тэтгэлэгийн асуудлыг тусгаж зохицуулж болох боловч энэ

тохиодолд тэтгэлийн хэмжээ, тэтгэлэг төлөх нөхцөл, журмыг тухайн гэрээгээр нарийвчлан тохиролцож болох эсэх, хэрэв гэрээнд уг асуудлыг тусгасан бөгөөд тухайн гэрээнээс маргаан үүссэн тохиодолд тэтгэлгийн хэмжээний талаар Тэжээн тэтгэх гэрээг зохицуулсан болон хуулийн бусад холбогдолтой заалтыг шүүх, бусад эрх бүхий этгээд эцэг, эх эрх үүргээ хэрэгжүүлэх гэрээний маргааныг шийдвэрлэхдээ хэрхэн ойлгох талаар асуудал үүсч болзошгүй байна.

Энд анхаарах шаардлагатай зүйл нь Тэжээн тэтгэх тухай гэрээ нь одоогийн мөрдөж буй хуульд байгаа гэрээний төрөл ба эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ нь шинээр хуулийн төсөлд тусгаж буй гэрээ тул эдгээр гэрээний зохицуулалтыг хооронд нь уялдуулах, нийцлийг хангах шаардлагатай.

Гэрлэлтийн гэрээ, тэжээн тэтгэх гэрээний зохицуулалтын үйлдээ

Хуулийн төслийн 23 дугаар зүйлд Гэрлэлтийн гэрээнд “гэрлэгчид гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт цуцлагдсан, дуусгавар болсны дараа бие биенээ болон үр хүүхдээ тэжээн тэтгэх эрх, үүргийг тодорхойлох” асуудлыг тусгахаар заасан бол Тэжээн тэтгэх гэрээнд “Тэтгэлэг төлөгч болон тэтгэлэг авагч нь тэтгэлгийн хэмжээ, тэтгэлэг төлөх нөхцөл, журмыг харилцан тохиролцох” зэргээр заажээ.¹⁴

Дээрхээс харахад гэрлэлтийн гэрээнд тэжээн тэтгэх эрх үүргийг тодорхойлох нь хамтын амьдралын үед болон гэрлэлт дуусгавар болсны дараа үргэлжлэх боломжтой тусгагдсан бол тэжээн тэтгэх гэрээ нь зөвхөн гэрлэлт дуусгавар болсноос хойш тэтгэлгийн хэмжээ, нөхцлийг талууд тохиролцохоор хуулийн төсөлд заагтай тусгагджээ.

Түүнчлэн хуулийн төслийн 46.1-д Гэрлэгчид бие биеэ харилцан тэжээн тэтгэх үүргээ хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулж болно гэсэн хуулийн төслийн 51 дүгээр зүйлд заасан гэрээнээс агуулгын хувьд өөр төрлийн гэрээ байхаар төсөлд тусгасан байна.

Гэрлэлтийн гэрээ, эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээний зохицуулалтын үйлдээ

Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх тухай гэрээгээр хүүхэдтэй хамт амьдрах эцэг, эсхүл эх, тусдаа амьдрах эцэг, эсхүл эхийн хүүхдүүдтэйгээ харилцах, тэднийг хүмүүжүүлэхэд хүлээх үүргийг зохицуулах бол хуулийн төслийн 23.1-д Гэрлэгчид эд хөрөнгийн бус харилцаа, эрх, үүргийг зохицуулах гэрлэлтийн гэрээг гэрлэгчид харилцан тохиролцож байгуулж болно гэж заасан. Иймд гэрлэлтийн гэрээнд гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт дуусгавар болсны дараа эд хөрөнгийн бус харилцаа буюу үүнд хүүхдүүдтэйгээ харилцах, тэднийг хүмүүжүүлэхэд хүлээх үүргийг гэрлэгчид тохиролцож

¹⁴ Мөн хуулийн төслийн 45.2-т Гэр бүлийн гишүүд, гэрлэгчид бие биеэ, эцэг, эх нь хүүхдээ, хүүхэд нь эцэг, эх, төрлийн хүмүүсээ энэ хуульд заасны дагуу тэжээн тэтгэх үүрэгтэй гэж заажээ. Мөн 48.1-т Эцэг, эх нь насанд хүрээгүй, насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй нь тогтоогдсон хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй гэж тус тус заажээ.

болохоор байна.

Хуулийн төслийн зохицуулалтаас харахад нэгд, гэрлэгчид гэрлэлтийн гэрээ байгуулаагүй эсхүл гэрлэлтийн гэрээнд тухайн асуудлаар тохиролцоогүй бол эцэг, эхийн эрх, үүргийг хэрэгжүүлэх бие даасан гэрээг дараа нь байгуулж болохоор байна. Түүнчлэн гэрлэлтийн гэрээнд дээрх асуудал туссан бол тусдаа амьдарч байхдаа эсхүл гэрлэлт дуусгавар болсны дараа эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх асуудлыг бие даасан өөр гэрээгээр тохиролцох шаардлагагүй гэж үзэхээр байна.

5.Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;

5.1.Гэрлэлтийн гэрээний зохицуулалтыг Иргэний хуулийн зохицуулалттай нийцүүлэх

Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт Гэрлэлтийн гэрээ байгуулах асуудлыг шинээр зохицуулахаар тусгажээ. Гэрлэлтийн гэрээний дээрх зохицуулалтыг Иргэний хуулийн 132 дугаар зүйлтэй уялдуулах шаардлагатай.

Иргэний хууль, хуулийн төслийн холбогдох зохицуулалтыг доорх хүснэгтээр харьцуулан үзүүлье.

Иргэний хууль, Гэр бүлийн тухай хуулийн зохицуулалтын харьцуулалт	
Иргэний хууль	Тавдугаар хүснэгт Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

132 дугаар зүйл. Гэрлэгчид хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулах 132.1.Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам, гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох хөрөнгийг тодорхойлох, хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөлийг энэ хуульд нийцүүлэн байгуулсан гэрээний үндсэн дээр зохицуулж болно. 132.2.Гэрлэгчид хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлэх бөгөөд энэ шаардлагыг хангаагүй гэрээ хүчин төгөлдөр бус байна. 132.3.Гэрлэгчид хөрөнгийн эрхтэй холбогдсон гэрээг гэрлэлтээ бүртгүүлэхийн өмнө болон гэрлэсний дараа хэдийд ч байгуулж болно. 132.4.Гэрлэлтээ бүртгүүлэхийн өмнө байгуулсан гэрээ гэрлэлтийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. 132.5.Гэрлэгчид гэрээндээ хөрөнгийн бус харилцааг зохицуулсан, гэрлэгчдийн хэн нэгний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг илтэд доройтуулсан, эрхийн чадамжийг хязгаарласан нөхцөл тусгахыг хориглоно.	23 дугаар зүйл.Гэрлэлтийн гэрээний хэлбэр 23.1.Гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлэх, гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт дуусгавар болсны дараа тэдний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцаа, эрх, үүргийг зохицуулах гэрлэлтийн гэрээг гэрлэгчид харилцан тохиролцож байгуулж болно. 23.2.Гэрлэлтийн гэрээнд дараах зүйлийг тусгаж болно: 23.2.1.гэр бүлийн гишүүдийн хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгөнөөс ашиг хүртэх, хуваах; 23.2.2.гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгийг тодорхойлох; 23.2.3.гэрлэлт дуусгавар болсны дараа гэр бүлийн гишүүдэд ногдох эд хөрөнгө болон хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгийг шилжүүлэх, хамтран өмчлөх, эсхүл хууль тогтоомжид зааснаар өөр нөхцөл тогтоох; 23.2.4.гэрлэгчид гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт цуцлагдсан, дуусгавар болсны дараа бие биенээ болон үр хүүхдээ тэжээн тэтгэх эрх, үүргийг тодорхойлох; 23.2.5.гэрлэгчид гэрлэлт, гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг энэ хуулийн 13.5-т зааснаас бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэх; 23.2.6.гэр бүлийн хэрэгцээний зардлыг хуваарилах; 23.2.7.хууль тогтоомжоор харшлаагүй гэр бүлийн харилцааны бусад асуудал.
--	---

Зургаадугаар хүснэгт

Гэрлэлтийн гэрээнд тусгах хөрөнгийн эрх болон хөрөнгийн бус харилцаатай
холбоотой асуудал

Иргэний хууль	Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл	Тайлбар
Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв,	23.2.1.гэр бүлийн гишүүдийн хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгөнөөс ашиг хүртэх, хуваах; 23.2.2.гэр бүлийн гишүүдийн хуваарьт хөрөнгийг тодорхойлох;	
гэрлэгч тус бүрээс зардлыг хариуцах журам,	23.2.6.гэр бүлийн хэрэгцээний зардлыг хуваарилах;	

гэрлэлтийг цуцалсан нөхцөлд ногдох хөрөнгийг тодорхойлох,	23.2.3.гэрлэлт дуусгавар болсны дараа гэр бүлийн гишүүдэд ногдох эд хөрөнгө болон хамтран эзэмших, өмчлөх дундын эд хөрөнгийг шилжүүлэх, хамтран өмчлөх, эсхүл хууль тогтоомжид зааснаар өөр нөхцөл тогтоох;	
хөрөнгийн эрхтэй холбогдсон бусад нөхцөл		
Гэрээнд тусгах хөрөнгийн бус харилцаа буюу амины эрхийн харилцаа		
Зохицуулалт байхгүй	23.2.4.гэрлэгчид гэр бүлийн хамтын амьдрал, эсхүл гэрлэлт цуцлагдсан, дуусгавар болсны дараа бие биенээ болон үр хүүхдээ тэжээн тэтгэх эрх, үүргийг тодорхойлох;	Тэжээн тэтгэх гэрээтэй холбоотой асуудлыг гэрээнд тусгах боломжтой.
Зохицуулалт байхгүй	23.2.5.гэрлэгчид гэрлэлт, гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг энэ хуулийн 13.5-т зааснаас бусад тохиолдолд эвлэрүүлэн зуучлалаар шийдвэрлүүлэх;	Гэр бүлийн маргаан шийдвэрлэх журам, тодруулбал, эвлэрүүлэн зуучлалаар маргаан шийдвэрлүүлэх асуудлыг гэрээнд тусгана.
Зохицуулалт байхгүй	23.2.7.хууль тогтоомжоор харшлаагүй гэр бүлийн харилцааны бусад асуудал.	
Зохицуулалт байхгүй	13.7.Гэрлэгчид гэрлэлтийн гэрээнд хүүхэд, хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, тэтгүүлэх, эсхүл хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, эд хөрөнгийн талаар дурдсан эсэхээс үл хамаарч, гэрлэлт цуцлуулах үед харилцан тохиролцож болно.	

Дээрх хүснэгтээс харахад Иргэний хуулийн 132 дугаар зүйл, хуулийн төслийн холбогдох зохицуулалт хоорондоо агуулгын хувьд давхардаж байгаа боловч нэр томъёоны хувьд өөр байна. Тухайлбал, Иргэний хуулийн 132 дугаар зүйлд “Гэрлэгчид гэрлэгч тус бүрээс өрхийн төсөв, зардлыг хариуцах журам” гэж заасан нь хуулийн төслийн 23.2.1-т “гэр бүлийн гишүүдийн хамтран эзэмших, өмчлөх дундын эд

хөрөнгөнөөс ашиг хүртэх, хуваах” гэж заасантай зөрчилдөж байна. Иргэний хуулийн “гэрлэгч тус бүрээс зардлыг хариуцах журам” гэсэн нь төслийн “гэр бүлийн хэрэгцээний зардлыг хуваарилах” гэсэнтэй агуулгын хувьд адил боловч өөр нэр томъёотой байгааг жигдлэх шаардлагатай. Энэ хүрээнд одоо мөрдөж буй Иргэний хуулийн заалттай хуулийн төслийг нийцүүлэх шаардлагатай.

Хуулийн төслийн 23 дугаар зүйлд Гэрлэлтийн гэрээг гэрлэгчид хоорондоо байгуулж болохоор тусгажээ. Хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1-д зааснаар уг гэрээнд гэрлэгчид эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус харилцааг аль алиныг тусгаж болохоор заасан. Харин Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 3 дугаар дэд бүлэгт гэр бүлийн хөрөнгийн эрхийг зохицуулсан бөгөөд тус хуулийн 132 дугаар зүйлд гэрлэгчид хөрөнгийн эрхээ гэрээгээр зохицуулахаар тусгажээ.

Дээрхээс харахад хуулийн төсөлд тусгасан гэрлэлтийн гэрээ нь Иргэний хуулийн 132 дугаар зүйлд заасан гэрээний зохицуулалтаас агуулгын хувьд өргөн буюу эд хөрөнгийн эрхээс гадна эд хөрөнгийн бус харилцааг зохицуулахаар байна. Гэвч хуулийн төслийн уг зохицуулалтыг Иргэний хуулийн холбогдох зохицуулалттай нэр томъёо, агуулга, хэрэглээний хувьд уялдуулсан холбогдох өөрчлөлтийг дагалдан гарах хуулийн төсөлд тусгаагүй байна.

Эрх зүйн онолын хувьд буюу тусгайгаас ерөнхий гэх зарчмын дагуу авч үзвэл, Гэр бүлийн тухай хуулийг Иргэний хуулийн тусгай зохицуулалт гэж үзэх эсэхээс дээрх хоёр хуулийн зохицуулалтын хоорондын уялдаа, харьцаа, эрэмбэ, шүүхэд хэрэглэх асуудал шийдвэрлэгдэнэ. Хэрэв Гэр бүлийн тухай хуулийг Иргэний хуулийн тусгай зохицуулалт гэж үзвэл тус хуулийн зохицуулалт Иргэний хуулийн холбогдох зохицуулалттай заавал нийцсэн байх шаардлагагүй гэдгийг энд онцолж байна.

Дараагийн дугаарт, Иргэний хуулийн 132.5-д “Гэрлэгчид гэрээндээ хөрөнгийн бус харилцааг зохицуулсан ... нөхцөл тусгахыг хориглоно” гэж заасныг хүчингүй болгох шаардлагатай.

Хөрөнгийн бус харилцаа гэдэгт Гэр бүлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд зааснаар гэрлэгчид нь гэр бүлээ төлөвлөх, оршин суух газар, эрхлэх ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхтэй, мөн бие биедээ үнэнч байх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн гишүүд нь бие биеэ халамжлах, хүндэтгэх, тэжээн тэтгэх, туслах үүрэгтэй. Эдгээр харилцаа нь Гэрлэлтийн гэрээний зүйл байж болохоор төсөлд тусгагдсан тул Иргэний хуулиас дээрх зохицуулалтыг хасах нь зүйтэй.

5.2.Хуулийн төслийн Гуравдугаар зүйлийн гарчиг, агуулгын хоорондын зөрчил, хийдлийг арилгах

Хуулийн төслийн 23.2-т гэрлэлтийн гэрээнд дараах зүйлийг тусгаж болно гэж гэрээний зүйл, агуулгыг заасан боловч, тухайн зүйлийн гарчиг нь “Гэрлэлтийн гэрээний хэлбэр” гэж тухайн зүйлийн агуулгыг бүрэн илэрхийлээгүй байна. Иймд тухайн зүйлийн гарчгийг “Гэрлэлтийн гэрээний агуулга, хэлбэр” гэж өөрчлөх. Мөн хуулийн төслийн Гуравдугаар бүлэг нь зөвхөн гэрлэлтийн гэрээг байгуулах асуудлыг бус тухайн гэрээний тодорхойлолт, агуулгыг тусгасан зохицуулалттай байх тул Гуравдугаар бүлгийн гарчгийг “Гэрлэлтийн гэрээ, түүнийг байгуулах” гэж өөрчлөх шаардлагатай.

5.3.Бусад

Хуулийн төслийн 21.2-т энэ зүйлийн 21.1-д шаардлага хангасан хамтран амьдрагчид хамтын амьдралын явцад эхнэр, нөхрийн адил эрх, үүрэг хүлээнэ гэж заажээ. Энэ нь цаг хугацааны хувьд зөвхөн хамтран амьдрах хугацаанд хамаарах бөгөөд хамтын амьдрал дуусгавар болсны дараа эхнэр, нөхрийн адил үүрэг хүлээхгүй гэсэн агуулгыг илэрхийлж байна.

Харин хуулийн төслийн 21.4-т “Хамтран амьдрагчдын хамтын амьдрал дуусгавар болох тохиолдолд бие биеэ тэжээн тэтгэх, өв залгамжлах эрх, үүрэг үүсэхгүй” гэж заасан нь гэрлэлтээ хууль ёсоор бүртгүүлэхийг хөхүүлэн дэмжсэн зохицуулалт бөгөөд БНСУ зэрэг улсад гэрлэлтээ бүртгүүлээгүй бол хамтын амьдралын явцад эхнэр, нөхрийн адил эрх, үүрэг хүлээх боловч, хэн нэг нь нас барсан тохиолдолд өв залгамжлах эрхгүй байдаг зохицуулалттай адил зорилтыг агуулсан хуулийн заалт болжээ. Энэ тохиолдолд хуулийн төслийн 21.2 дах хэсгийг “хуульд өөрөөр заагаагүй бол эхнэр, нөхрийн адил” гэж тодотгох шаардлагатай.

6.Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;

Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг төсөлд тодорхой тусгасан байна.

7.Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;

Хуулийн төслийн 90 дүгээр зүйлд буюу гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт дараах зохицуулалтыг нэмж тусах шаардлагатай.

- гэрлэлт цуцлахад хүүхдийн асрамж тогтоох асуудлаар шүүгчийн захирамжийн дагуу шинжээчээр ажиллах, энэ чиглэлээр шүүхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах,
- Гэр бүлийг эвлэрүүлэх, хүүхдийг эцэг, эхийн аль нэгний асрамжид үлдээх асуудлаар шүүхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, дүгнэлт гаргах чиг үүргийг гүйцэтгэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх,
- Гэр бүлийг эвлэрүүлэх, хүүхдийг эцэг, эхийн аль нэгний асрамжид үлдээх асуудлаар шүүхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, дүгнэлт гаргах аргачлал, төлбөрийн хэмжээ, стандартыг батлах, хэрэгжилтийг хангах,

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шүүхээс гэр бүл цуцлах шийдвэр гаргахдаа хүүхдийг буюу хүүхдүүдийг эцэг, эхийн хэний асрамжид үлдээхийг шийдвэрлэхдээ Гэр бүл, хүүхэд залуучуудын газраас шинжээчийн баг томилохоор захирамж гарган шийдвэрлэж байна.

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын албан хаагчтай хийсэн ярилцлагаар энэ чиглэлээр дараах асуудал тулгамдаж байна.

“Шүүгчийн захирамжийн дагуу шинжээчийн баг ажиллуулж энэ ажиллагааг хийж байгаа. Гэвч хуульд манай байгууллагаас шинжээчээр ажиллана гэсэн заалт байдаггүй. Жилд нэг хэлтэс дээр 50-аас 60 гаруй шүүгчийн захирамж ирдэг. Шинжээчийн баг зөвхөн нэг удаагийн уулзалтаар дүгнэлт гаргах боломжгүй. Хамгийн багадаа тухай хүнтэй 2-оос 3 удаа уулзаж ярилцах мөн утсаар холбогдох, боломжтой бол утсаар дуудаж нэмэлт асуулт асуух зэргээр

ажиллагаагаа явуулдаг. Нэг өрх айл очиход 3-оос 4 хүүхэдтэй айл байдаг. Үүнээс 1 хүүхдэд зарцуулах цаг хамгийн багадаа 4-өөс 5 цаг байдаг.”

Иймд Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын шинжээчээр ажиллах чиг үүргийг хуульд тусгах шаардлагатай. Ингэснээр тус байгууллага шинжээчээр ажиллах орон тоог нэмэгдүүлэх, цалин хөлсийг төсөвт суулгах, албан хаагчдыг мэргэшүүлэх боломж бүрдэнэ.

8.Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;

Хуулийн төсөл энэ шаардлагыг хангасан байна.

9.Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;

Хуулийн төслийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Эвлэрүүлэн зуучлагч эвлэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын мэргэжил, арга зүйн дэмжлэгийг авч, хамтран ажиллах, эсхүл магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно” гэж заажээ.

Практикт эвлэрүүлэн зуучлалын шатанд талуудыг эвлэрүүлэх арга хэмжээ авахад гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас мэргэжил, арга зүйн туслалцаа авахын зэрэгцээ энэ чиглэлийн төрийн бус байгууллагаар дээрх ажлыг гүйцэтгүүлэх нь зүйтэй юм. Гэхдээ уг харилцааг хуулийн төсөлд нарийвчлан зохицуулах шаардлагатай.

10.Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;

Хуулийн төслөөр төлбөр, хураамж тогтоож байгаа зүйл заалт байхгүй. Энэ шаардлагыг хангасан.

11.Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;

Хуулийн төслөөр аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг зохицуулаагүй тул энэ шаардлагыг хангаж байгаа болно.

12.Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;

Хуулийн төсөлд хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгагдаагүй байна.

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Мөн гэрлэгчид гэрлэхдээ, гэрлэснийхээ дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдэлнэ” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн чөлөөтэй харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн

нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасантай хуулийн төсөл нийцэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэгт “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж тус тус заасантай хуулийн төсөл нийцэж байна.

13.Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;

Хуулийн төсөл нь энэ шаардлагыг хангасан байна.

14.Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

Хуулийн төсөл нь энэ шаардлагыг хангасан байна.

15.Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;

Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгосон зохицуулалт ороогүй байна.

16.Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.

Хуулийн төслийн 94 дүгээр зүйлд хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг заажээ

3.3.“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ

Энэ хэсэгт Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн зарим шинэ зохицуулалт нь дагаж мөрдөж, хэрэгжүүлэх боломжтой эсэхийг авч үзэх болно. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг тооцохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллага болох шүүх, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар зэрэг төрийн байгууллагад үүрэг болгосон заалтыг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар санал авч, үйл ажиллагааны тайлан болон тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар шалгалаа.

Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хуулийн төслийн зохицуулалтыг дагаж мөрдөх буюу хэрэгжүүлэх боломжтой эсэхийг, тухайлбал, хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд байгаа эсэх, тэдгээр этгээдэд тухайн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг шалгаж тооцов. Ингэхдээ дараах хоёр асуултад хариулах байдлаар тус шалгуур үзүүлэлтийг үнэлсэн.

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх
2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Гэрлэх нөхцөл

Хуулийн төслийн 5.2, 5.3, 5.4, 5.5 дэх хэсэгт заасан гэрлэх нөхцөл зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

3.3.1 Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 5 дугаар зүйл Гэрлэх нөхцөл хэсэгт шинэлэг зохицуулалт оруулсан нь хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал тулгамдаж байгаатай холбоотой, түүнийг шийдвэрлэхэд чиглэсэн ач холбогдол бүхий зохицуулалт байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө сайн дураараа, харилцан тохиролцсоны үндсэн дээр эрүүл мэндийн шинжилгээ өгч, эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно” гэсэн сайн дурын шинжтэй зохицуулалтыг гэрлэгчдэд санал болгосон байна. Эрүүл мэндийн шинжилгээ өгөх зохицуулалтыг хүчин төгөлдөр үйлчилж буй Гэр бүлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд төслийн 7 дугаар зүйлд тус тус нарийвчлан зохицуулсан байна. Харин эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно гэсэн зохицуулалтыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хариуцан зохион байгуулах бөгөөд хүчин төгөлдөр үйлчилж буй Гэр бүлийн тухай хуульд гэр бүлийн боловсрол олгох сургалт зохион байгуулах ажлыг тус байгууллагын чиг үүрэгт тусган, үүрэгжүүлээгүй боловч тус байгууллага гэр бүлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж ирсэн туршлагатай буюу хэрэгжүүлэх субъект тодорхой байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно” гэсэн сайн дурын шинжтэй зохицуулалтыг тусгасан бөгөөд заавал биелүүлэх шинжийг агуулаагүй тул садан төрлийн холбоотой эсэхээ мэдэхээр бүртгэлийн байгууллагад хандах гэрлэгчдийн тоо харьцангуй бага байх, цаашлаад хууль санаачлагчийн зорьсон зорилгод хүрэхгүй, хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. Садан төрлийн лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас гаргадаг тул гэрлэлтээ иргэний бүртгэлд бүртгүүлэхдээ лавлагаа авахаар иргэдэд хүндрэл учруулахгүйгээр хэрэгжүүлэх боломжтой. Хэрэв лавлагаагаар садан төрлийн холбоотой нь тогтоогдсон бол Хуулийн төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсэгт заасан гэрлэхэд харшлах шалтгаан болж мөн хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан “гэрлэх нөхцөл”-ийн зохицуулалт хэрэгжих ач холбогдолтой.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.4 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно” гэж шинэ зохицуулалт оруулж ирсэн байна. Садан төрлийн холбоотой хүмүүс хоорондоо гэрлэж цус ойртсоноос оюуны хомсдолтой, эрүүл бус хүүхэд төрөх ба 1000 төрөлт тутам 10 байвал хэвийн гэж үздэг байна. Монгол Улсад 1000 төрөлт тутмын 13 нь оюуны хомсдолтой, эрүүл бус хүүхэд төрж, хүн амын 6.1 хувь нь цус ойртсон байх магадлалтай

бөгөөд энэ тоо жил ирэх тусам өсөж байна.¹⁵ Гэрлэгчид хүүхэдтэй болсны дараа гэрлэлтээ батлуулах явдал түгээмэл ажиглагдаж буй энэ үед садан төрлийн холбоотой эсэх лавлагаа авах шаардлагыг хуульд тусгах нь 2 дахь хүүхдэд учирч болох эрүүл мэндийн сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Тус заалтыг хэрэгжүүлэх байгууллага нь Шүүх шинжилгээний ерөнхий газар байна. Шүүх шинжилгээний байгууллагын ДНХ-ийн шинжилгээний лабораторийн Эрүү, Иргэн болон Гэр бүлийн тухай хуульд заасан хэрэг маргааныг шийдвэрлэхэд ихээхэн түлхэц үзүүлж байгаа шинжилгээний нэгд “Эцэг, эх, төрөл садны холбоо хамаарлыг тогтоох шинжилгээ” багтдаг байна. ДНХ-ийн шинжилгээний лаборатори нь эцэг, эхийг үр хүүхэдтэй нь, нэг удмын эрэгтэй ах дүүс мөн эсэхийг, эмэг эхийг ач охинтой нь, өвөг эцгийг ач хүүтэй нь зэрэг өвөг удмын нэгдүгээр болон хоёрдугаар үе хүртэлх үе удамд шинжилгээ хийж жилд дунджаар 500 орчим иргэний хэрэгт эцэг, эх, ах дүү тогтоох шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.¹⁶



Эх сурвалж: Шүүх шинжилгээний ерөнхий газар

Дээрх графикаас харвал Иргэний хэрэгт ДНХ-ийн шинжилгээ хийлгүүлэх явдал өсч буй дүр зураг ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэгт шүүгчийн захирамжаар ДНХ шинжилгээ хийх нь дийлэнх хувийг эзэлж буй бөгөөд нийт хийгдсэн ДНХ-ийн шинжилгээг хэргийн төрлөөр авч үзвэл 16% нь эцэг, эх, садан төрөл тогтоох шинжилгээ байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхдээ нөгөө талын өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй эсэх мэдээллийг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно” гэсэн шинэ зохицуулалтыг оруулсан байна. Тус заалтыг хэрэгжүүлэх байгууллага нь Улсын бүртгэлийн ерөнхий газар бөгөөд дээрх төрлийн лавлагаа нь үйлчилгээ үзүүлж буй лавлагаа мэдээллийн төрөлд багтаж байна.

3.3.2 Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

¹⁵ Хуулийн төслийн үзэл баримтлал

¹⁶ Шүүх шинжилгээний ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл, 5 сар, 2023


Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө сайн дураараа, харилцан тохиролцсоны үндсэн дээр эрүүл мэндийн шинжилгээ өгч, эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно” гэсэн сайн дурын шинжтэй зохицуулалтыг гэрлэгчдэд санал болгосон байна.

...Гэрлэлтийн асуудал нь гэр бүл төлөвлөлттэй холбоотой учраас орон нутагт энэ чиглэлээр сургалт их хийгддэг. Гэрлэлтийн гэрчилгээг олгох үед Иргэний бүртгэлийн газартай хамтран Гэр бүлийн тухай хуулийн гэрлэгчдийн эрх үүргийг таниулж гарын үсгийг нь зуруулж олгож байгаа. Энэ чиг үүрэг манай байгууллагад асуудалгүй явагдаж болно. Цаашид хэдэн цагийн сургалтанд суусан байх ёстой, ийм үүрэг хариуцлагатай байх ёстой гэдгийг илүү хуульчилж оруулж өгч үүрэг хариуцлагыг нь гэрлэж байгаа хүмүүсийн анхных нь өдрөөс ойлгуулж таниулах нь чухал. Гэрлэсэн хойноо чи ингэхгүй, тэгэхгүй байна, эцэг, эхийнхээ үүргийг гүйцэтгэхгүй байна гэсэн хүмүүс зөндөө байна. 21 аймаг 9 дүүрэг дээр гэрлэх ёслолын ордонтой болж байгаа үүн дээр манай байгууллагаас бага ч гэсэн гэрлэгчдийн эрх үүргийг таниулах, хуулийн заалтуудыг сануулаад гарын үсэг зуруулж баталгаажуулах ажлыг хийдэг байх зорилготой байгаа...

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төлөөлөлтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төлөөлөлтэй ярилцлагын судалгаа хийхэд хуулийн төслийн гэр бүлийн боловсрол олгох сургалтыг тус байгууллагаас тогтмол зохион байгуулж ирсэн бөгөөд практикт хэрэгжих боломжтой байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно гэсэн сайн дурын шинжтэй зохицуулалтыг тусгасан бөгөөд заавал биелүүлэх шинжийг агуулаагүй тул садан төрлийн холбоотой эсэхээ мэдэхээр бүртгэлийн байгууллагад хандах гэрлэгчдийн тоо харьцангуй бага байх, цаашлаад практикт хэрэгжихгүй байх эрсдэлтэй заалт байна.



Эх сурвалж: Садан төрлийн холбоотой эсэх лавлагаа гаргасан тоо, Улсын бүртгэлийн ерөнхий газар

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээллээр садан төрлийн холбоотой эсэх лавлагаа авах иргэдийн тоо жил тутам өсөн нэмэгдэж байна. Мөн садан төрлийн холбоотой эсэх лавлагааг гэрлэх зорилгоор авдаггүй талаар ярилцлагын

судалгааны үеэр онцолж байв. Мөн хуулийн төсөл батлагдсанаар УБЕГ-аас садан төрлийн лавлагааг гэрлэхийг хүсэгчдэд гаргаж өгөх боломжтой боловч садан төрөлтэйгээ гэрлэхээс урьдчилан сэргийлэх, удмын санг хамгаалах зорилгод хүрэхгүй буюу садан төрлийн лавлагаа нь тухайн хүмүүсийн 2-3 үеийн мэдээллийг гаргах боломжтой түүнээс дээш үеийн мэдээлэл байдаггүй учир дутагдалтай байна.

...Манай байгууллагаас садан төрөл мөн гэсэн лавлагаа гаргадаг ч садан төрөл биш гэсэн тодорхойлолт, лавлагаа гардаггүй. Гэхдээ садан төрөл биш байна гэсэн лавлагааг гаргахтай холбоотой зохицуулалт хуульд оруулж өгснөөр гаргаж өгөх боломжтой. Тухайн этгээдийг цаашаа хэдэн үеэрээ холбогдсон гэдгийг мэдэхгүй. Ер нь гэрлэлтээ бүртгүүлэх гэж байгаа хүнд маш их ачаалал үүсэх эрсдэлтэй байна. Одоо иргэд гэрлэлтээ бүртгүүлэхдээ эрүүл мэндийн шинжилгээ өгөөд бүртгүүлдэг байгаа. Энэ давхар ачааллаас болж гэрлэлтээ бүртгүүлэх иргэдийн тоо цөөрч албан бус бүртгэл хийлгэх магадлал ихэснэ. Манай байгууллагад иргэд гэрлэлтээ бүртгүүлэхэд садан төрлийн лавлагаа авч байсан тохиолдол байхгүй. Зөвхөн гэрлэлт бүртгэлгүй гэсэн лавлагаа авч байж гэрлэлтийг нь бүртгэдэг. Харин өөрсдийн бизнес, өв залгамжлалын асуудалтай холбоотойгоор л садан төрлийн лавлагаа авч байгаа. Хэрвээ садан төрөл биш гэсэн лавлагааг авахаар бол бидний зүгээс тухайн хүмүүсийн 2-оос 3 үеийн мэдээллийг харж байж л гаргах боломжтой түүнээс хойшхи үеийн мэдээлэл байдаггүй. Тэгэхээр гэрлэлтээ бүртгүүлэхээр ирж байгаа хүмүүсийн хаагуураа холбогдсоныг тухайн этгээдүүд өөрсдөө мэдэхгүй байхад бид нар мэдэх боломжгүй. Тиймээс манайхаас авч байгаа лавлагаа бодит үнэн зөв байх нь боломжгүй юм...

Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөөлөлтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын хэсгээс

Төслийн 5 дугаар зүйлийн 5.4 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно” гэж шинэ зохицуулалт оруулж ирсэн байна. Удам зүйн шинжилгээ /Kinship/-ний хувьд өвөг удмын гурав болон түүнээс дээш үеийн үеэл, хаяал, бүл, өвөг, удмуудад шинжилгээ хийх боломжийг бүрдүүлдэг бөгөөд тус шинжилгээ хийхэд генетик генологийн судалгаа шаардлагатай байна. Монгол Улсын хэмжээнд энэ төрлийн суурь судалгаа /харьцуулах мэдээллийн сан/ өнөөдрийг хүртэл байхгүй хэвээр байна. Цаашид Шүүх шинжилгээний байгууллагын харьяанд ДНХ-ийн шинжилгээний лабораторийн дэргэд удам зүйн шинжилгээний лабораторийг байгуулбал цус ойртолтын асуудлыг шийдвэрлэх цаашлаад гэмт хэрэгтнийг удам зүйн модоор илрүүлэх хүртэл ач холбогдолтой. Үүний тулд дараах ажлуудыг хийх шаардлагатай. Үүнд:

1. Монгол Улс, цаашлаад цус ойртолт өндөр байгаа гэгдэх аймаг, сумдад цус ойртолтын түвшин хэр байгааг тогтоох суурь судалгааг хийх.
2. Монгол Улсын хэмжээнд удам зүйн шинжилгээ /Гаплогруп тогтоох, генетик генологи/-г овог, угсаагаар хийх.
3. Удам зүйн шинжилгээ хийх батлагдсан арга зүйг боловсруулах.
4. Удам зүйн шинжилгээ хийх төрөлжсөн лаборатори, мэргэжилтэн бий болгох зэрэг шаардлагууд тулгарч байна.

Дээрх суурь судалгааг хийж хэрэгжүүлэхдээ Монгол улсад хүн амын төлөөлөх түвшнийг бүрэн тогтоох түүврийг аймаг, сумд цаашлаад овог удмаар хийж, филогенетикийн модыг зохиомол оюун ухаан ашиглан үндэсний хэмжээний

мэдээллийн сан бий болгон ажиллах нь зүйтэй. Тус судалгааг хийж практик хэрэглээнд нэвтрүүлснээр удам төрлийн хувьд, генетик зайн хувьд хэр хэмжээтэй байна вэ? Цус ойртолт үүсэх магадлал хэдэн хувь байна вэ? Аль овог угсааны хүн байна вэ? гэсэн асуултуудад хариулт өгөх боломжтой болох юм.

Аливаа нэг дээжийн ДНХ-ийн мэдээллийг ДНХ-ийн мэдээллийн сан /Генетик генологийн сан/-д хайхад тухайн дээжийн ДНХ-ийн мэдээлэлд хамгийн ойр байж болох мэдээллийг магадлалын түвшингээр эрэмбэлэн үзүүлдэг. Энэхүү хайлтын үр дүнд тулгуурлан тухайн овог, угсаа, удамд удамшлын, хавдрын болон бусад хэлбэрийн өвчин байсан эсэхийг тэмдэглэн авч мэдээллийн сан үүсгэн цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжтой болно. Генетик генологийн судалгаанд аутосомын ДНХ, нэг нуклейтидын олон хэлбэршил зэргийг ашиглан хоёр бодгалийг генетик зайн хувьд хэр ойр байгааг тогтоож болдог боловч судалгааны зорилго, чиглэлээс хамааран өвөг дээдсээс уламжлагдан ирсэн митохондрийн ДНХ, Y хромосомын ДНХ зэргээр бодгаль хоорондын генетик хамаарлыг тогтоох боломжтой.

Дээрхээс үзвэл, хуулийн төслийн удам зүйн шинжилгээ хийх заалтыг практикт хэрэгжүүлэхийн тулд суурь судалгааны түүвэр хийх, дээж сонголтын арга зүй, лабораторийн шинжилгээ, филогенетикийн мод үүсгэх цаашлаад эх өгөгдлийн сан үүсгэх тусгайлсан арга зүй, стратеги боловсруулан ажиллах шаардлагатай байна. Түүнчлэн хүн амын төлөөлөх түвшнийг нийт хүн амын нэг хувь байхаар тогтооно гэж үзвэл суурь судалгаанд 32400 хүнийг хамруулах бөгөөд нэг хүнд хийгдэх судалгааны бодит зардал /дээж цуглуулах, ДНХ ялгах, ПГУ явуулах, капилляр электрофорези, мэдээллийн санд оруулах/-д 120-150 мянга орчим төгрөг зарцуулах талаар Шүүх шинжилгээний ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэлд дурджээ. Иймд дээрх суурь судалгааг гүйцэтгэсний дараа тус заалт практикт хэрэгжих боломжтой бөгөөд одоогийн нөхцөлд цус ойртолтыг тогтоох суурь мэдээлэл улсын хэмжээнд бүрдээгүй байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхдээ нөгөө талын өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй эсэх мэдээллийг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно гэсэн шинэ зохицуулалтыг оруулсан байна.

Улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6-д Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдэд энэ хуулийн 12.2, 12.3-т зааснаас бусад мэдээллийг тухайн иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрлөөр, эсхүл хязгаарлалттайгаар буюу нотариатчаар дамжуулан энэ хуулийн 12.7-д заасан зорилгоор хуульд заасан үндэслэл, журмын дагуу өгөх бөгөөд үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 21.2-т заасны дагуу тогтооно, 12.8-д Энэ хуулийн 12.2, 12.6-д заасан мэдээллээс лавлагаа, мэдээлэл өгөх, энэ хуулийн 12.3-т заасан мэдээлэлтэй танилцах, мэдээлэл өгөх журмыг тус тус Засгийн газар батална гэж заажээ. Өөрөөр хэлбэл гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхдээ нөгөө талынхаа өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй

эсэх мэдээллийг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно гэсэн хуулийн төслийн заалт практикт хэрэгжих боломжгүй буюу тухайн иргэний зөвшөөрлөөр л олгогдох боломжтой байна. Түүнчлэн нөгөө талынхаа өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй эсэх мэдээллийг гэрлэхийг хүсэгчдэд мэдэгдэх нь тодорхой зорилго, үр дүнд хүрэхээргүй, иргэний эрх, хувийн нууцад халдахаар буйг УБЕГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын үеэр онцолж байв.

...Энэ бол боломжгүй. Одоо эцэг нь төрсөн хүүхдийнхээ лавлагааг ч авах боломжгүй байгаа. Эцэг, эх байх эрхээ хасуулсан хүн лавлагаа авах гээд байгаа юм уу гэдгийг бид мэдэх боломжгүй. Тухайн 2 хүн яг үнэнээсээ гэрлэх гэж байгаа юмуу гэдэг нь баталгаагүй байдаг. Эхнэр, нөхөр 2 гэрлэх гэж байгаа бол бие биенийхээ асуудлыг мэдсэн байх ёстой. Заавал лавлагаа аваад байх шаардлагагүй. Манай зарим эмэгтэйчүүд гадаад хүнтэй суух гээд түүнээсээ хамаг юмаа нуусан, хүүхэд, нөхрөө нуусан тохиолдлууд зөндөө байдаг. Гэхдээ энэ чинь хувь хүний нууцад хамаарах асуудал. Үүнийг заавал нөгөө хүнд нь мэдэгдүүлэх гээд байх шаардлага байхгүй. Үнэхээр гэрлэх гэж байгаа бол тэр хүний хүүхэдтэй байна уу, нөхөртэй байсан уу гэдэг тийм чухал биш хоорондоо ярилцсан байхад хангалттай...

Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөөлөлтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын хэсгээс

Гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд заасан Гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

3.3.3 Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт Гэрлэгчдийн хэн нэг нь энэ хуулийн 9.4.4-т заасан үүргээ зөрчсөн шалтгаанаар гэрлэлт цуцлах бол гэр бүлийн дундын эд хөрөнгийн өөрт ногдох хэсгийн 25 хүртэлх хувийг нөгөө талдаа шилжүүлнэ гэсэн нөхцөлт зохицуулалтыг тусгаж өгсөн байна. Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт гэрлэгчид гэр бүлийн харилцаанд хүлээх ёс суртахууны үүргийг тусгаж, 9.4.4 дахь хэсэгт бие биедээ үнэнч байх үүрэгтэйг, төслийн 14.4-т Гэрлэгчдийн хэн нэгний нэхэмжлэлээр энэ зүйлийн 14.3-т заасан хөрөнгийн хэмжээг шүүх шийдвэрлэнэ. Мөн төслийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт Гэрлэгчдийн хэн нэг нь энэ зүйлийн 9.4.4-т заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын эрх, нэр төр, алдар хүндэд хохирол учруулсан бол Иргэний хуулийн 230.2-т заасны дагуу гэм хорын хохирол нөхөн төлүүлэх нэхэмжлэл шүүхэд гаргаж болно гэж тус тус зохицуулсан байна. Дээрхээс үзвэл гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваана гэж хэрэгжүүлэх субъектийг хуулийн төсөлд тодорхойлж өгсөн байна.

3.3.4 Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Хуулийн төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт гэрлэгчид гэр бүлийн харилцаанд хүлээх ёс суртахууны үүргийг тусгаж, 9.4.4 дахь хэсэгт бие биедээ үнэнч байх үүрэгтэйг зааж өгчээ. Хэдий тийм боловч хуулийн төсөлд үнэнч байх үүргийн талаар нарийвчлан тодорхойлоогүй байна. Үүний улмаас практикт хэрэгжихэд зарим

саад бэрхшээл тулгарахаар буйг шүүгчтэй хийсэн ярилцлагын үеэр онцолж байв. Тухайлбал гэрлэлтээ албан ёсоор цуцлаагүй боловч хоорондоо тохиролцож тусдаа амьдарч байсан хосууд өөр хүнтэй хамтран амьдрах нь үнэнч байх үүргээ зөрчсөн гэдэгт хамаарах эсэх тодорхойгүй, гэр бүлийн дундын эд хөрөнгийн 25 хүртэлх хувийг нөгөө талдаа шилжүүлэхийг хуулиар хатуу тогтоох нь цаг үеийн хувьд болоогүй гэж үзэж байна. Эндээс үзвэл үнэнч байх үүргээ зөрчсөн тохиолдолд гэр бүлийн дундын эд хөрөнгийн 25 хүртэлх хувийг нөгөө талдаа шилжүүлэх зохицуулалт нь практикт хэрэгжих боломжгүй байна.

...Үнэнч байх үүргээ хэрхэн тодохойлох вэ? Хэрвээ ийм нарийвчилсан байдлаар хуульд оруулж ирэх юм бол цаг үеийн хувьд манайд одоохондоо болоогүй. Нөгөөтэйгүүр манай гэр бүлийн тухай хуульд гэр бүлийн хоорондын асуудлаа тохиролцоод гэрээ байгуулах эрх нээлттэй байгаа. Үнэнч байх үүргийг өөрсдөө гэрээндээ тодорхойлж болно. Ямар нөхцөл байдал үүсвэл хоорондын харилцаандаа бие биедээ үнэнч байх гэдэг харилцаа алдагдах, ямар тохиолдол үүсвэл ямар хувиар тохиролцох вэ гэдэг гэрээний нөхцөлөө өөрсдөө тохиролцоод үүсгэх харилцаа байхад зайлшгүй хуулиар хатуу тогтоож өгөх нь өөрөө үр дагавар үүсгэхгүй. 25, 75 хувь гэж хатуу хуульчлан зохицуулах нь одоогийн цаг үед тохиромжтой биш. Үнэнч байх гэдэг маань их өргөн хүрээний хувь хүний харилцааны асуудал тул нарийн харилцаа руу орж хуульчилж өгөх боломжгүй гэж харж байна...

...Солонгос Улс гэр бүлийн хуулиасаа үнэнч байх, гэр бүлээс гадуур харилцаа үүсгэвэл баривчлах гэх зэрэг шийтгэл ноогдуулдаг зохицуулалтаа авчихсан. Гэр бүл цуцлах шалтгаан бол болдог. Гэр бүл цуцлахад энэ хүний ийм нөхцөл байдал нөлөөлөөд үүрэг хариуцлага хүлээлгээд хуульд эд хөрөнгийг бий болгосон үүрэг оролцооноос хамааралтайгаар шүүх энэ талд нь илүү давуу эрх олгох уу гэсэн эрх хэмжээ шүүхэд (манай улсад ч гэсэн) байгаа. Магадгүй би ингэх юм бол энэ автомашин, 2 өрөө байрнаас олж байгаа хөрөнгөө гэрээндээ дунд руу оруулахгүй, миний захиран зарцуулах эрх зэргээр зохицуулж болно. Энэ бол гэр бүл доторх чөлөөт байдал. Үүн рүү хэтэрхий их орж болохгүй...

Шүүгчтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын хэсгээс

Гэрлэлттэй адилтгах харилцаа

Хуулийн төслийн 21 дүгээр зүйлд заасан Гэрлэлттэй адилтгах харилцаа зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

3.3.5 Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Төслийн 21 дүгээр зүйлд заасан Гэрлэлттэй адилтгах харилцааг тогтоох тохиолдолд шүүх байгууллага хэрэгжүүлэх үндсэн субъект бол, УБЕГ хавсрах байдлаар зарим шаардагдах материалыг гаргаж өгөхөөр байна. Хуулийн төслөөр гэрлэлттэй адилтгах харилцаатай байсныг тогтоохдоо 6 шалгуурыг хангасан байхыг шаардаж байна.

Үүнд:

- 21.1.1.цаашид гэрлэх зорилгоор хамт амьдарч байх;
- 21.1.2.хамтран амьдрагчид хоёулаа эсхүл хэн нэг нь өөр хүнтэй гэрлэлт бүртгүүлээгүй байх;
- 21.1.3.таваас доошгүй жил тогтмол хамтран амьдарсан;
- 21.1.4.эд хөрөнгө дундаа өмчилж байгаа, хамтын хөрөнгө бий болгосон;
- 21.1.5.хамтран амьдрагчид нэг оршин суух хаягт бүртгэлтэй;
- 21.1.6.хамтран амьдрагчид хүүхэдтэй болсон шаардлагууд багтаж байна.

Дээрх шаардлагыг хангаснаа шүүхэд нотлохын тулд хамтран амьдрагчдын зүгээс УБЕГ-аас гэрлэлт бүртгэлгүй лавлагаа, эд хөрөнгийн улсын бүртгэлийн лавлагаа, оршин суугаа хаягийн лавлагаа, төрсөн хүүхдийн лавлагаа авахаар байна.

3.3.6 Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Хуулийн төсөлд дээрх 6 шаардлагыг бүхэлд нь хангасан байхыг шаардсан нь хамтран амьдрагчаар тогтоолгоход иргэнд хүндрэл, чирэгдэл учруулахаар байна. Тухайлбал УБЕГ-аас 4 төрлийн лавлагааг авах бол таваас доошгүй жил тогтмол хамтран амьдарсныг тогтоох, цаашид гэрлэх зорилгоор хамтран амьдарч байсныг тогтооход шинжээч томилох, эсхүл объектив байдлаар тогтооход хүндрэлтэй зэрэг асуудал байна.

...Хамтран амьдрагч гээд заавал нэг хүний хаяг руу очих шаардлагагүй. Эхнэр нөхөр 2 ч гэсэн өөр өөр хаягтай явж байдаг. 2 эд хөрөнгөтэй бол тус тусдаа бүртгэлтэй явдаг. Үүнтэй адилаар заавал нэг хаяг дээр байх шаардлагагүй. Тиймээс заавал нэг хаяган дээр байх шаардлага нь утгагүй асуудал...

Улсын бүртгэлийн ерөнхий газрын төлөөлөлтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын хэсгээс

УБЕГ-аас авах 4 төрлийн мэдээлэл, лавлагааг тус байгууллагаас олгох бүрэн боломжтой байна. Хэдий тийм боловч хамтран амьдрагчид заавал нэг хаяг дээр бүртгэлтэй байх шаардлага нь орчин цагт тохиромжгүй, 2 эд хөрөнгөтэй бол тус тусдаа бүртгэлтэй хамтран амьдрагч төдийгүй гэрлэлтээ бүртгүүлсэн гэр бүлүүд олон болохыг УБЕГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын үеэр онцолж байв. Эндээс үзвэл гэрлэлттэй адилтгах харилцааг тогтооход авч үзэх зарим шаардлага практикт хангагдахааргүй байна.

...Энэ зохицуулалт гэр бүлийн хуулийн гол үзэл санааг өөр тийш нь эргүүлсэн байна. Улс үндэстэн оршин тогтнохын үндэс бол гэр бүл. Гэр бүлийн харилцаанд эхнэр, нөхөр байгаа бол гэрлэлтээ батлуул, салсан бол тэнд байгаа эхнэр, нөхөртэйгөө гэр бүлээ батлуул гэсэн үүрэг байх ёстой. Үүрэг үүсч, үүргээ биелүүлж байж эрх араас нь дагалдана. Үүргээ биелүүлээгүй л бол эрх эдэлнэ гэдэг ойлголт байж болохгүй. Хэрвээ ийм зохицуулалт орж ирэх юм бол гэр бүлийн харилцаа замбараагүй болно. Гэрлэлт батлуулна гэсэн зохицуулалт одоо хуульд байсаар байтал энэ зохицуулалт арай хэтэрсэн юм болов уу гэж харж байна. Үнэхээр үр хүүхэдтэй болоод цаашдаа хамт амьдрах зорилготой байгаа л бол гэрлэлтээ бүртгүүлэх үүрэг байна. Хэрвээ тэр үүргээ биелүүлээгүй бол эрх эдлэхгүй байх ёстой. Одоо байгаа хуулийн зохицуулалтаар зохицуулаад явж байхад гэр бүлийн дундын эд хөрөнгөд хүүхдэд эд хөрөнгө ноогдохгүй, энэ асуудал яригдахгүй байгаа. Зөвхөн Иргэний хуулийн 108 дугаар зүйл дундын өмчөөр асуудлыг шийдвэрлэж байгаа. Энэ зохицуулалт орж ирэх юм бол Гэр бүлийн хуулийн концепц өөрөө алдагдах юм байна. Манайх одоогийн нөхцөлд үүнийг хуулиар дэмжих хэрэггүй...

Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

Гэрлэлттэй адилтгах харилцааны талаар шүүхийн байгууллагын төлөөлөл цаг үеэ олоогүй, манай нөхцөлд тохиромжгүй зохицуулалт гэсэн саналтай байна. Түүнчлэн гэрлэлт бүртгүүлэх үүргийг хүүхэд хүлээхгүй учир эцэг, эхийн хариуцлагагүй байсны үр дагаврыг хүүхэд хүлээхгүй байхад хууль санаачлагч илүүтэй анхаарах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Тухайлбал хамтран амьдрагчийн хүүхэд бусад хүүхдүүдийн адил

тэжээгчээ алдсаны тэтгэмж авах эрх нь хамтын амьдралтай байснаа тогтоолгосноор явж ирсэн. Гэтэл төслийн гэрлэлттэй адилтгах харилцааг тогтоохдоо 6 шалгуур үзүүлэлт хангасан байхыг шаардах нь хүүхдэд ямар үр дагавартай болохыг тооцож илүү нарийвчилсэн зохицуулалт хийх хэрэгтэй гэсэн саналыг гаргаж байна..

...Өв залгамжлалын маргаан үүсэхгүй байгаа бол хамтран амьдрагчид авах эрх нь үүснэ. Өөрөөр хэлбэл маргаан үүсэхгүй бол энэ хоёр хамтын амьдралтай байсан, ийм эд хөрөнгө бий болгосон гэвэл тэр хүн авч үлдэх эрх нь нээлттэй байх нь зүйтэй. Заавал тэрийг чамд өгүүлэхгүй гээд хэн нэгэнд өгөх буюу гуравдагч этгээд ээж, аав, ах, дүү нартаа өгөх боломж бий болгох нь утгагүй. Тэр эд хөрөнгийг бий болгосон хүн авах нь шударга ёсонд нийцнэ. Хэрвээ маргаан үүсч байгаа бол тэр хүн өв залгамжлалаа яагаад шаардах эрхтэй юм гэдгээ Иргэний хуулийн 521-р орж ирнэ. Тэгэхээр үүсэхгүй бус хязгаарлах ёстой. Тиймээс Иргэний хуулийн 520, 521 дүгээр зүйл рүү яаж холбогдох вэ? Амины харилцааг тийм хатуу хязгаарлах нь учир дутагдалтай...

Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

Түүнчлэн хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.2-д энэ зүйлийн 21.1-д шаардлага хангасан хамтран амьдрагчид хамтын амьдралын явцад эхнэр, нөхрийн адил эрх, үүрэг хүлээнэ гэж заасан боловч 21 дүгээр зүйлийн 21.4-д хамтран амьдрагчдын хамтын амьдрал дуусгавар болох тохиолдолд бие биеэ тэжээн тэтгэх, өв залгаамжлах эрх, үүрэг үүсэхгүй гэж заасан нь хоорондоо зөрчилдөж байна. Шүүгчтэй хийсэн ярилцлагын үеэр энэ заалтууд практикт хэрэгжихгүй хэрэв өв дээр маргаан үүсэхгүй байгаа бол хамтран амьдрагчид авах эрх нь үүснэ. Хэрэв маргаан үүсэхгүй бол ийм эд хөрөнгийг хамтран бий болгосон гэвэл өвлөх эрх нь нээлттэй байх шаардлагатай талаар онцолж байв. Өөрөөр хэлбэл дээрх өв залгамжлах эрх, үүрэг үүсэхгүй гэсэн заалт практикт хэрэгжих боломжгүй байна.

Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах

Хуулийн төслийн 43 дугаар зүйлд заасан Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

3.3.7 Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 43 дугаар зүйлийн 43.1-д эцэг, эх байх эрхийг нь хязгаарласан, хассан тухай шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болмогц шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас уг хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулахаар, 43.2-д шүүх эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан этгээдийн эрхийг сэргээхдээ зан үйлд нөлөөлөх сургалтад хамрагдсан эсэхийг харгалзахаар, 43.3-д хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр боловсруулж, зохион байгуулахаар тус тус хэрэгжүүлэх субъектыг тодорхойлж өгчээ. Тухайлбал эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект нь ШШГБ, шүүхийн байгууллага, ГБХЗХГ байна.

...Эцэг, эх байхыг хязгаарласан хүмүүст сургалт явуулах нь зүйн хэрэг. Зан үйлийн сургалтанд суугаад ухамсарлаж болно. Насан туршид нь хязгаарлана гэсэн хатуу зохицуулалт байж болохгүй. Дийлэнх нь амьдралд алдаж онож явдаг. Тэр тусмаа харгис хэрцгий хүмүүс ч гэсэн цаг хугацааны хувьд өөрчлөгдөх боломжтой. Тийм учраас энэ зохицуулалт байх боломжтой. Үүний талаар илүү нарийвчлан зохицуулахдаа эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан хүн зан үйлийн сургалтанд хамрагдаад үр дүнд хүрээд бодитойгоор ажил хийсэн эсэх (нийгмийн даатгал төлсөн байдлаар харагдана) гэдгийг шүүх үнэлнэ. Энэ зохицуулалт хэрэгтэй...

Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

3.3.8 Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Хуулийн төслийн зохицуулалтаас харвал хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр боловсруулж, зохион байгуулах чиг үүргийг хүлээж байна. Тус байгууллагын төлөөллөөс дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх боломж, бололцоотой эсэхийг тодруулахад сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө байдаг, эдгээр хүмүүст сургалт, нөлөөлөл, соён гэгээрүүлэх ажлыг гүйцэтгэж ирсэн байна. Түүнчлэн хуульд эдгээр хүмүүст байнгын шинжтэй сургалт хүмүүжлийн ажил хийх ёстой гэсэн зохицуулалт орвол манай байгууллагаас үүнийг хэрэгжүүлэх бүрэн боломжтой бөгөөд тохиромжтой гэсэн байр суурьтай байв. ГБХЗХГ-аас хорооны нийгмийн ажилтанг чадавхижуулах тал дээр голлож ажилладаг бөгөөд нийгмийн ажилтнуудаар дамжуулан хороо, суманд эцэг, эхэд зориулсан сургалт хийх бүрэн боломжтой байна.

Мөн эцэг, эх байх эрхээ хасуулсан, хязгаарлуулсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг ГБХЗХГ болон Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтарч зохион байгуулах талаар хуулийн төсөлд тусгах нь тус зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлнэ гэсэн саналтай байна.

...Хүүхдийн эрхийн улсын байцаагч эцэг, эх байх эрхийг хасах саналыг шүүхэд гаргадаг. Эргээд шүүхээс эрхийг нь хасахгүй гэсэн шийдвэр гаргах эсхүл 3-аас 6 сарын хугацаатай эцэг эх байх эрхийг нь хязгаарладаг. Энэ хугацаанд сургалтын ажлыг манай газарт эсхүл хорооны хамтарсан багт даалгадаг. 2022 онд эцэг, эх байх эрхийг 3-аас 6 сар хязгаарласан миний мэдэх 3 тохиолдол байгаа. Харин эцэг, эх байх эрхийг бүрмөсөн хассан тохиолдол ховор байдаг. Хүний нөөцийн хувьд зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах боломжгүй байгаа. Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулаад байгаа хүмүүсийг харахад ихэнхи нь архины хамааралтай. Цагдаагийн байгууллагаас архины эмчилгээнд явуулж байгаа хүмүүс байдаг. Манай газартай холбогдож тэр болгон даалгаж өгдөггүй. Хүүхдийг эцэг, эхээс нь түр хязгаарлагчид хүүхдийн эрхийг хамгаалах үүднээс бид эцэг, эхтэй нь ажиллах нөхцөл боломж хэцүү байдаг. Зөвхөн хүүхэдтэй ажиллаад хүүхдээ хамгаалж байна гээд байдаг гэтэл хүүхдийг эцэг, эхтэй нь эргэн нэгтгэхэд маш хүндрэлтэй байдаг. Тиймээс энэ ажлыг маш сайн ялгаж салгаж уялдуулах нь чухал. Эцэг, эхийг хүүхэдтэй эргэн нэгтгэх ажлыг ганцхан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас биш тэр хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг Сэтгэцийн эрүүл мэндийн төвтэй хамтарч хийх маягаар мэргэшсэн байгууллагуудыг оруулж өгөх шаардлагатай. Манай байгууллага сэтгэцийн өөрчлөлттэй хүнд ямар сургалт тусалцаа үзүүлэх вэ гэдэг асуудал учир дутагдалтай байна. Тухайн хүн сэтгэл зүйн хувьд асуудалтай байхад бид зүгээр хөгжлийн хөтөлбөр, янз бүрийн сургалтуудад хамруулаад байдаг. Гэтэл сэтгэл зүйг нь өөрчлөхгүйгээр тэр сургалтын үр дүн гарахгүй Тиймээс сэтгэл зүйн мэргэшсэн байгууллагуудтай хамтран ажиллах нь маш үр дүнтэй. Гэвч Сэтгэцийн эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах санал хүргүүлэхэд манайх хууль, журмаар тийм үүрэг хүлээгээгүй учир танай байгууллагаас дамжих хүмүүст эмчилгээ хийх боломжгүй гэдэг. Тиймээс зан үйлд нөлөөлөх сургалтыг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэхгүй бол одоо бидний хийж байгаа сургалтын ажил хангалттай үр дүнд хүрэхгүй байна...

ГБХЗХГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Хүүхдийн тэтгэлэг

Хуулийн төслийн 49 дүгээр зүйлд заасан Хүүхдийн тэтгэлэг зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

3.3.9 Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 49 дүгээр зүйлийн 49.1-д тэтгэлгийн хэмжээ, хугацааг тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулж шүүх аргачлалын дагуу тогтооно, 49.2-д хүүхдийн тэтгэлгийн хэмжээ, хугацаа тогтоох аргачлалыг Засгийн газар тогтооно гэж тус тус заажээ. Дээрх заалтыг хэрэгжүүлэх субъект нь шүүх болон Засгийн газар байна.

3.3.10 Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Шүүхийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын судалгааны үеэр тэтгэлгийн хэмжээ, хугацааг тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулж шүүх аргачлалын дагуу тогтоох боломжтой эсэх талаар санал авахад орлоготой уялдуулах зохицуулалт практикт хэрэгжих боломжгүй, хэрэгжүүлэхийн тулд илүү нарийвчлах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Тухайлбал тогтмол цалинтай эсэх, нийгмийн даатгалын шимтгэл төлдөг эсэх, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлах эсэх зэрэг олон асуудал тулгархаар байна. Түүнчлэн орлогын хэмжээг тогтоохын тулд тусдаа шинжээч томилох эсэх, шинжээчийн дүгнэлт бодитой гарах боломжтой эсэх нь эргэлзээтэй байна. Өөрөөр хэлбэл цалингийн хэмжээг үндэслэхээр бол хөдөлмөрийн хөлснөөс доод хэмжээгээр цалинждаг хүний орлогын 50 хувиас хэтэрч болохгүй гэх тохиолдолд доод хэмжээ 550.000 төгрөгийн 50 хувиар 3 хүүхдийн өдөр тутмын хэрэгцээ хангагдах боломжгүй юм. Тэтгэлгийн хэмжээг тогтоох ажиллагаа нь хүүхдийн эрх, ашгийн асуудлыг хөндөж буй чухал асуудал тул одоогийн хуулийн амьжиргааны түвшингийн хэмжээгээр тогтоосон тэтгэлгийг тогтмол хугацаанд шүүхээс тогтоосон хэмжээгээр авах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах нь зүйтэй гэсэн саналыг шүүгчтэй хийсэн ярилцлагын үеэр онцолж байв.

...Энэ зохицуулалт орж ирснээр шүүх дээр маргаан үүсч хүүхдийн эрх ашиг хөндөгдөх нөхцөл үүснэ. Хүмүүс орлогоо нууна. Тэрийг тогтоохын тулд шүүхэд ажиллагаа хийгдэх юм уу эсхүл тэтгэлэг тогтоолгох гээд байгаа тал нь тогтоох юм уу гэдэг асуудал тулгарна. Тухайн хүний бүх орлогын эх үүсвэрийг мэддэггүй л бол тогтооход хэцүү. Мөн тухайн хүний эд хөрөнгө өөр хүний нэр дээр байгаа тохиолдолд хэрхэх. Үүнд бас л хүүхдийн эрх ашиг хөндөгдөнө. Засгийн газрын амьжиргааны доод түвшингээр тогтоож байгаа нь цаг үеийн нөхцөл байдалтайгаа уялдсан байгаа. Улаанбаатар хотод 314400, 11 хүрээгүй хүүхэд үүний 50 хувиар бөгөөд үүнээс дээш нэхэмжлэхэд бидний цалин хүрэлцэхгүй. Амьжиргааны түвшингөөр тогтоож байгаа энэ хэлбэр хамгийн зүй зохистой гэж үзэж байна. Хэрэв орлогыг шүүх тогтоож орлогын хэмжээгээр шийднэ гэх юм бол шүүх үүнтэй холбоотой ажиллагаа хийгээд мөд хэргээ шийдэж чадахгүй. Тэгэхээр үүний ард хүүхэд тэтгэлгээ авч чадахгүй хохирно. Яагаад гэвэл шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш тэтгэлэг авч эхэлнэ. Хэдэн жил үргэлжилсэн маргаан ч байна. Тиймээс Засгийн газраас тогтоосон амьжиргааны түвшин хэмжээгээр явах нь зүйтэй. Үнэхээр өндөр орлоготой бол хоорондоо тохиролцоод шүүх дээр ороод ирвэл шүүх тэр хэмжээгээр батлаад өгч байгаа...

Хүүхэд үрчлүүлэх


Хуулийн төслийн 65, 67, 83 дугаар зүйлд заасан Хүүхэд үрчлүүлэх зохицуулалтын практикт хэрэгжих боломжид хийсэн дүн шинжилгээ

3.3.11 Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх

Хуулийн төслийн 67 дугаар зүйлийн 67.1-д хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үрчлэлийн зөвлөл гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд ажиллана. Үрчлэлийн зөвлөлийн ажиллах журмыг гэр бүл, хүүхдийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална, 83 дугаар зүйлийн 83.6-д харьяатын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын гэр бүл, иргэнд үрчлүүлэх талаар дүгнэлт гаргах үүрэг бүхий Гадаад Үрчлэлтийн зөвлөл ажиллахаар зохицуулалт тусгаж өгчээ. Мөн төслийн 67 дугаар зүйлийн 67.2 болон 83 дугаар зүйлийн 83.7-д үрчлэлтийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн хүүхэд үрчлүүлэх асуудлыг шүүх шийдвэрлэхээр байна. Эндээс үзвэл хүүхэд үрчлэлттэй холбогдох зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект нь шүүх, ГИХГ, ГБХЗХГ байна.

3.3.12 Төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж бололцоо байгаа эсэх

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Гэр бүлийн тухай хуулийн 55.7-д “Сум, дүүргийн Засаг дарга хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтийг хянан үзэж, үрчлүүлэх эсэх тухай шийдвэрийг 20 хоногт багтаан гаргана”, 58.1-д “Гадаадын иргэн Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах тухай хүсэлтээ өөрийн орны эрх бүхий байгууллагаар дамжуулан Монгол Улсын эрх бүхий байгууллагад гаргана” гэж тус тус заасан байна. Үрчлэх эсэх талаар дүгнэлтийг одоо үйлчилж байгаа хуульд сум, дүүргийн Засаг дарга хянан үздэг байсан бол хуулийн төсөлд гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дэргэд Үрчлэлтийн зөвлөл хариуцахаар заасан нь гэр бүл, хүүхдийн чиглэлээр дагнан ажилладаг, илүү мэргэшсэн субъект буюу хамтарсан баг ажиллаж дүгнэлт хийхээр тусгасан, Үрчлэлтийн зөвлөлийн үнэлгээ, дүгнэлтийг шүүхээс үнэлж үрчлэх эсэх тухай шийдвэрийг гаргах нь хүүхдийн эрх, ашиг хамгаалагдах урьдач нөхцөлийг бүрдүүлсэн байна.



Эх сурвалж: Улсын бүртгэлийн ерөнхий газар, Хүүхэд үрчлэлтийн тоон мэдээлэл

Дээрх графикаас харвал хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцсон тоо хүүхэд үрчлэлтээс илүү буюу сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж ирсэн байна. Хүчин төгөлдөр үйлчилж буй Гэр бүлийн тухай хуулиар хүүхэд үрчлүүлэх эсэх шийдвэрийг Засаг дарга гаргаж, хүүхэд үрчлэлтийг хүчингүйд тооцох эсэх шийдвэрийг шүүх гаргаж байна. Хуулийн төслийн хүүхэд үрчлэлтэй холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлэх байгууллага болох шүүхийн байгууллага болон ГБХЗХГ-аас тухайн зохицуулалт хэрэгжих боломж, бололцоотой эсэх талаар санал авахад ГБХЗХГ-т хүүхэд үрчлэлтийн асуудлаар дүгнэлт гаргах нь чиг үүрэгт нийцсэн, цаг үеэ олсон гэж үзэж байна. Харин хуулийн төслийн 67 дугаар зүйлийн 67.1-д хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үрчлэлийн зөвлөл гэснийг орон тооны байхаар хуулийн төсөлд тусгах саналтай байна. Энэ нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, тухайн асуудлын ач холбогдлыг үнэлж буй явдал гэж үзэж байна.

...Хүүхэд үрчлэлтийн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх нь зохимжтой. Хүүхэд үрчлэлтийг хүчингүй болгохдоо шүүхээс шийдвэрлэхэд үрчлүүлэх тухай шийдвэрийг Засаг дарга гаргах нь зохимжгүй...

...Асрамж, халамжийн төвд байгаа хүүхдүүдийн үрчлэлтийн асуудал манай байгууллагад харьяалагддаг. Бусад орон нутагт бол харьяа газрын Засаг дарга шийдвэрлээд явчихдаг. Гэтэл Засаг дарга манай байгууллага руу танайх үрчлэлийн дүгнэлт гаргаж өг гээд явуулдаг. Бидэнд хуульд заасан тийм эрх, үүрэг байхгүй. Гадаадын иргэнд үрчлүүлэх асуудлын хувьд бид дүгнэлт бичээд харьяа яам руу явуулдаг. Манай дээр энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр бол боловсон хүчний хувьд ажиллах хүч байхгүй. Үрчлэх эсэх шүүхийн шийдвэр гаргах хүртэлх өмнөх процесс бол манай байгууллагад хамааралтай байна. Тиймээс боловсон хүчний асуудал шийдэгдэж чадвал зүй зохистой зохицуулалт гэж харж байна. Гэр бүлийн тухай хуулийн төсөлд гэр бүлийн дагнасан шүүхтэй болох тухай зохицуулалт оруулвал эвлэрүүлэн зуучлал, үрчлэлт, гэр бүл цуцлалт зэрэг тэнд цогцоор явагдах боломжтой. Үрчлэлтийн зөвлөлийг оруулахдаа орон тооны бус гэдэг маягаар оруулахаар үндсэн ажлаа хийхгүй тухай байгууллагын чиг үүрэг алдагдах эрсдэл бий болдог. Тэгэхээр орон тооны гэсэн хувилбараар хийх нь зохимжтой. Сүүлийн 5 жилийн хугацаанд үрчлэлтийн асуудал их өсч байгаа хүмүүсийн амьдрах арга барил, хэв маяг өөрчлөгдөж байна. Мөн одоо асрамжийн газар байгаа

хүүхдүүдийг гэр бүлийн орчинд байлгах нь хүүхдийн эрүүл саруул өсөх, боловсрол эзэмших, зөв хүмүүжэхэд маш их ач холбогдолтой...

ГБХЗХГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Үрчлэлтийг хүчингүйд тооцох асуудлыг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар шүүх шийдвэрлэж байгаа билээ. Хуулийн төслөөр үрчлэлтийг хүчингүйд тооцохоос гадна үрчлэх эсэх шийдвэрийг шүүх гаргахаар тусгасан нь шүүхийн байгууллагын ачааллыг нэмэгдүүлэхээр байна. Тухайлбал үрчлэлтийг хүчингүйд тооцуулахаар хандах маргааны тоо тасралтгүй өсөн нэмэгдэж буйг дээрх графикаас харж болно. Түүнчлэн тус зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо бий эсэх талаар саналыг шүүхийн байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын үеэр тодруулахад шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг уртасгаж иргэдийн эрх ашгийг хөндөх, нөгөөтэйгүүр шүүхийг төрийн чиг үүргийн байгууллага шиг болгох нь буруу гэсэн байр суурьтай байна. Хэдий тийм боловч хүүхэд үрчлэлтийн асуудлыг шүүх шийдэх нь илүү нухацтай, хүүхдийн эрх ашиг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой гэсэн байр суурьтай байна. Хуулийн төслийн үрчлэлттэй холбоотой зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхийн тулд шүүгчийн орон тоог нэмэх шаардлагатай байна.

...Үрчлэлтийг хүчингүй болгох асуудал шүүх дээр ачаалал их үүсгэж байна. Цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн шилжилттэй холбогдож үрчлэлт хийгдсэн, одоо тэрийг больё гээд шүүх дээр орж ирэхэд хийхгүй хатуу байя гэхээр нэн тэргүүнд хүүхдийн эрх ашиг яаж зөрчигдөж байна вэ гэдэг асуудалтай. 4 дүгээр сар гарснаас хойш 3, 4 хэрэг шийдсэн байна. 1-ийг нь хангаад 2-ыг нь хэрэгсэхгүй болгосон. Нөгөө талаар одоо үрчлэлт хийгдэж байгаа асуудал ямар ч замбараагүй, шалгуур байхгүй байна. Яагаад үрчилж авах гээд байгаа юм гэхээр өргөдөл аваад ирсэн гэдэг. Шүүх аваад шийдэх нь нэг талаас шүүх илүү нухацтай хандаж яагаад үрчлүүлэх гээд байгаа юм, учир шалтаан нь юу юм, хүүхдийн эрх ашиг хөндөгдөх үү гэх зэрэг асуудал дээр шүүхийн харах өнцөг өөр, бодитойгоор шийдвэр гаргана. Тэгэхээр шүүх дээр ирэх нь зөв ч, шүүхийн ачааллыг улам нэмэгдэнэ. Мөн үрчлэлтийг хүчингүй болгохгүй байх нь өөрөө үр дагавар үүсгэдэг. Үрчлэлтийг хүчингүй болгох үндэслэл хуульд байхгүй байхад үрчлэлтийг хүчингүй болгохгүй гэж тайлбарлаад шийддэг. Юм болгоныг шүүх рүү аваад ирж шүүхийн ачааллыг нэмээд байдаг тэр чинээгээрээ хүний эрх, ашиг зөрчигдөх байдал шүүх дээр үүсч байна. Хэрэг маргааныг шийдэхийн тул нотлох баримтыг цуглууж тал талаас нь дүгнэлт хийсний дараа хэрэг маргааны эцсийн шийдвэрийг гаргадаг. Иймэрхүү байдлаар шүүхийг төрийн чиг үүргийн байгууллага шиг болгох юм бол ажил хэрэг явагдахгүй. Үрчлэлтийн асуудал шүүх дээр маш их орж ирж байгаа...

Шүүгчтэй хийсэн ярилцлагаас

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” зэрэг бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан байх бөгөөд хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгасан хэрэгцээ, шаардлага, зорилтыг зарчмын хувьд хангасан байна гэж үзлээ.

Хуулийн төсөлд гэр бүлийн харилцаанд гэрлэлтийн гэрээ, тэжээн тэтгэх гэрээнээс гадна нөхөн үржихүйн туслах аргыг ашиглах гэрээ, эцэг эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээ, үрчлэгчтэй байгуулах гэрээ зэрэг хэд хэдэн гэрээний төрлүүд шинээр орж ирсэн байна. Эвлэрүүлэн зуучлагч, хүүхдийн шинжээч, хүүхдийн сэтгэл зүйч, хүүхэд, гэр бүлийн мэргэжилтэн, үрчлэлтийн зөвлөл, гэр бүл, хүүхэд залуучуудын газар, хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллага зэрэг хэд хэдэн хоорондоо уялдаа холбоо бүхий субъектүүд гэр бүл, хүүхдийн харилцаанд мэргэшээгүй, мэргэшсэн байдлаар оролцож байна.

Мөн түүнчлэн гэрлэлт цуцлах, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хүүхдийн овог, нэр өөрчлөх, хүүхдийн эцэг эх тогтоох, шүүхээс хүүхэд үрчлэх, үрчлэлтийг хүчингүй болгох, хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах маргаан, хүүхдийн эд хөрөнгийн маргаан, гэрээний маргаан, төрөл садантайгаа харилцахыг хориглосон маргаан, эцэг эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээлгэх хүсэлт, тэжээн тэтгэхтэй холбогдох маргаан, тэтгэлэгтэй холбогдох маргаан, асран хамгаалах харгалзан дэмжихтэй холбогдсон маргаан, эцэг эх тогтоох маргаан зэрэг гэр бүлийн харилцааны олон төрлийн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхээр хуулийн төсөлд тусгасан байна. Энэхүү зохицуулалтууд нь хүүхдийн эрх, ашиг сонирхол, гэрлэгчдийн эрх, ашгийг илүү мэргэшсэн түвшинд хамгаалах гэсэн зорилтыг харуулж байна. Энэхүү нөсөр ажиллагааг бусад салбарын хэргийг шийдвэрлэхийн хажуугаар шүүхээс хэрэгжүүлэхээр байгаа нь шүүгч, шүүхийн ачааллыг нэмэгдүүлж, эрх нь зөрчигдсөн этгээдийн эрх, ашиг сонирхлыг бүрэн дүүрэн хамгаалахад хүндрэл учруулах юм. Хуулийн төслөөс үзвэл гэр бүлийн чиглэлээр дагнан эдгээр хэрэг маргааныг шийдвэрлэх, үйл ажиллагааг явуулах цогц тогтолцоог бий болгох буюу гэр бүлийн шүүхийг байгуулах шаардлага үүсэхээр байна.

Зорилгод хүрэх байдал. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, хуулийн төслөөр тавьсан зорилгыг хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулан судалсан бөгөөд хуулийн төслийн зохицуулалт нь ерөнхий байдлаар зарчмын хувьд зорилгодоо хүрэх байдлыг хангасан байна. Үүнд зорилгодоо хүрэх байдлыг дараах байдлаар үнэлж дүгнэлээ.

Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт заасан гэрлэлтийн гэрээний зохицуулалт үндсэн агуулга, зарчмын хувьд зорилгодоо нийцсэн ч гэрлэлтийн гэрээ нь Иргэний хуулийн 125.1 дүгээр зүйл тодорхойлсон гэрлэлтийн гэрээг зааж байгаа эсэх, эдгээрийн уялдаа холбоог хуулийн төслийн холбогдох хэсэгт заах шаардлагатай байна. Иргэний хуулийн 132.5 дугаар зүйлд гэрээнд эд хөрөнгийн бус амины харилцааг зохицуулахыг хориглохоор заасан нь Хуулийн төслийн 23.1-т заасан гэрлэлтийн гэрээгээр эд хөрөнгийн бус харилцааг зохицуулна гэсэнтэй зөрчилдөж байгаа тул зөвхөн эд

хөрөнгийн харилцааг зохицуулахаар хуулийн төслийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4-т садан төрлийн лавлагаа, ДНХ-ийн шинжилгээ авч болох талаар заасан нь хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгод хүрэх ач холбогдолтой зохицуулалт болсон байна. Гэхдээ энэхүү лавлагаа авахыг үүрэгжүүлж өгөх нь хуулийн төслийн зорилгыг илүү үр дүнтэй болгоход туслахаар байна.

Хуулийн төслийн 28 дугаар зүйлд нөхөн үржихүйн туслах аргыг ашигласны үр дүнд төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоохтой холбогдсон зохицуулалт нь үүнтэй холбогдох гэрээнээс үүссэн эцэг, эхийг тогтоох маргаанд гэрээний талуудын үүргийг баталгаажуулж, эрх ашгийг хамгаалах төдийгүй цаашлаад хүүхдийн эрх ашгийг хамгаалах ач холбогдолтой зохицуулалт байна. Нөхөн үржихүйн туслах аргыг ашиглан хүүхэдтэй болох шинэ харилцаа аль хэдийн үүсч хуульд тогтоомжид тусгалаа олсон нь түүний суурь хууль болох гэр бүлийн тухай хуульд холбогдох зохицуулалт орж эцэг, эх тогтоосноор шүүх дээрх эцэг, эх тогтоолгох маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэхээр байна.

Хуулийн төслийн 49 дүгээр зүйлд хүүхдийн тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулан шүүхээс тогтоохоор заасан нь хуулийн төслийн тэтгэлгийн хэмжээг өсгөх, тэтгэлгийг төлөгддөг болгох гэсэн хуулийн зорилтод хүрэх боломжгүй байна. Учир нь шүүхээс тэтгэлэг төлөгчийн орлогыг үнэн, зөв тодорхойлоход хүндрэл бэрхшээл үүсч орлого тогтоох процесс ажиллагаа удааширч энэ хугацаанд хүүхдийн эрх, ашиг зөрчигдөхөөр байна. Тиймээс одоо мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тэтгэлгийн хэмжээг тогтоож байгаа зохицуулалт нь хамгийн боломжтой хувилбар байна гэж үзэж байна.

Хуулийн төслийн 65 дугаар зүйлээр хүүхэд үрчлэхийг Үрчлэлтийн зөвлөлийн дүгнэлт саналыг үндэслэн шүүх эцэслэн шийдвэрлэнэ гэж зааснаар үрчлэлтийн асуудлыг илүү мэргэшсэн түвшинд шийдэж шүүх түүний хууль эрх зүйн асуудлыг шалган шийдвэрлэх боломжийг олгосон байна. Шүүхээс жилд үрчлэлтийг хүчингүй болгох 2000 гаруй хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа нь шүүхэд ажлын ачаалал үзүүлээд зогсохгүй, хүүхдийн эрхийг ноцтой зөрчиж үрчлэх шийдвэр гаргаж буйг мөн харуулж байна. Тиймээс хуулийн төсөлд үрчлэлтийг шийдвэрлэх нарийвчилсан зохицуулалтыг оруулж өгснөөр хуулийн төслийн зорилгод хүрэх боломжийг бүрдүүлсэн байна.

Практикт хэрэгжих боломж. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн 5.2, 5.3, 5.4, 5.5 дэх хэсэгт заасан гэрлэх нөхцөл зохицуулалт, 14 дүгээр зүйлд заасан Гэрлэлт цуцлахад шүүх гэр бүлийн дундын эд хөрөнгийг хуваах зохицуулалт, 21 дүгээр зүйлд заасан Гэрлэлттэй адилтгах харилцаа зохицуулалт, 43 дугаар зүйлд заасан Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах зохицуулалт, 49 дүгээр зүйлд заасан Хүүхдийн тэтгэлэг зохицуулалт, 65, 67, 83 дугаар зүйлд заасан Хүүхэд үрчлүүлэх гэсэн заалтуудын практикт хэрэгжих боломжийг судалсан бөгөөд практикт турших ажиллагаа явуулах боломжгүй байсан учраас дээрх заалтуудыг хэрэгжүүлэх боломж байгаа эсэхийг санал авах замаар судалсан.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө сайн дураараа, харилцан тохиролцсоны үндсэн дээр эрүүл мэндийн шинжилгээ өгч, эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа гэр бүлийн боловсрол олгох сургалтад хамрагдаж болно” гэсэн заалтыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төлөөлөлтэй ярилцлагын судалгаа хийхэд хуулийн төслийн гэр бүлийн боловсрол олгох сургалтыг тус байгууллагаас тогтмол зохион байгуулж ирсэн бөгөөд практикт хэрэгжих боломжтой байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэх лавлагааг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно гэсэн сайн дурын шинжтэй зохицуулалтыг тусгасан бөгөөд заавал биелүүлэх шинжийг агуулаагүй тул садан төрлийн холбоотой эсэхээ мэдэхээр бүртгэлийн байгууллагад хандах гэрлэгчдийн тоо харьцангуй бага байх, цаашлаад практикт хэрэгжихгүй байх эрсдэлтэй заалт байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.4 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдаж болно” гэсэн заалт практикт хэрэгжих боломжгүй байна. Монгол улсын хэмжээнд хийгдсэн генетик генелогийн суурь судалгаа байхгүй байна.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэгт “Гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ бүртгүүлэхдээ нөгөө талын өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй эсэх мэдээллийг иргэний бүртгэлийн байгууллагаас авч болно” гэсэн заалт практикт хэрэгжих боломжгүй буюу тухайн иргэний зөвшөөрлөөр л олгогдох боломжтой байна. Түүнчлэн нөгөө талынхаа өмнөх гэрлэлтийн лавлагаа болон хүүхэдтэй эсэх мэдээллийг гэрлэхийг хүсэгчдэд мэдэгдэх нь тодорхой зорилго, үр дүнд хүрэхээргүй, иргэний эрх, хувийн нууцад халдахаар байна.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт гэрлэгчид гэр бүлийн харилцаанд хүлээх ёс суртахууны үүргийг тусгаж, 9.4.4 дахь хэсэгт бие биедээ үнэнч байх үүрэгтэйг зааж өгчээ. Хэдий тийм боловч хуулийн төсөлд үнэнч байх үүргийн талаар нарийвчлан тодорхойлоогүй байна. Үүний улмаас практикт хэрэгжихэд зарим саад бэрхшээл тулгарахаар буйг шүүгчтэй хийсэн ярилцлагын үеэр онцолж байв. Тухайлбал гэрлэлтээ албан ёсоор цуцлаагүй боловч хоорондоо тохиролцож тусдаа амьдарч байсан хосууд өөр хүнтэй хамтран амьдрах нь үнэнч байх үүргээ зөрчсөн гэдэгт хамаарах эсэх тодорхойгүй, гэр бүлийн дундын эд хөрөнгийн 25 хүртэлх хувийг нөгөө талдаа шилжүүлэхийг хуулиар хатуу тогтоох нь цаг үеийн хувьд болоогүй байна. Эндээс үзвэл үнэнч байх үүргээ зөрчсөн тохиолдолд гэр бүлийн дундын эд хөрөнгийн 25 хүртэлх хувийг нөгөө талдаа шилжүүлэх зохицуулалт нь практикт хэрэгжих боломжгүй байна.

Төслийн 21 дүгээр зүйлд 6 шаардлагыг бүхэлд нь хангасан байхыг шаардсан нь хамтран амьдрагчаар тогтоолгоход иргэнд хүндрэл, чирэгдэл учруулахаар байна. Тухайлбал УБЕГ-аас 4 төрлийн лавлагааг авах бол таваас доошгүй жил тогтмол хамтран амьдарсныг тогтоох, цаашид гэрлэх зорилгоор хамтран амьдарч байсныг тогтооход хүндрэл учрахаар байна. УБЕГ-аас авах 4 төрлийн мэдээлэл, лавлагааг тус байгууллагаас олгох бүрэн боломжтой байна. Хэдий тийм боловч хамтран амьдрагчид заавал нэг хаяг дээр бүртгэлтэй байх шаардлага нь орчин цагт тохиромжгүй, 2 эд

хөрөнгөтэй бол тус тус бүртгэлтэй явдаг байна. Эндээс үзвэл гэрлэлттэй адилтгах харилцааг тогтооход авч үзэх зарим шаардлага практикт хэрэгжих боломжгүй байна.

Төслийн 43 дугаар зүйлд заасан Эцэг, эх байх эрхээ хязгаарлуулсан, хасуулсан хүнийг зан үйлд нөлөөлөх сургалтад хамруулах чиг үүргийг ГБХЗХГ хэрэгжүүлэх боломж, бололцоотой эсэхийг тодруулахад сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө байдаг, эдгээр хүмүүст сургалт, нөлөөлөл, соён гэгээрүүлэх ажлыг гүйцэтгэж ирсэн туршлагатай буюу практикт хэрэгжих боломжтой байна.

Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1-д тэтгэлгийн хэмжээ, хугацааг тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулж шүүх аргачлалын дагуу тогтооно, 49.2-д хүүхдийн тэтгэлгийн хэмжээ, хугацаа тогтоох аргачлалыг Засгийн газар тогтооно гэж заасныг практикт хэрэгжих боломжтой эсэх талаар санал авахад орлоготой уялдуулан тэтгэлгийн хэмжээг тогтоох зохицуулалт практикт хэрэгжих боломжгүй, хэрэгжүүлэхийн тулд илүү нарийвчлах нь зүйтэй гэсэн байр суурьтай байна. Түүнчлэн орлогын хэмжээг тогтоохын тулд тусдаа шинжээч томилох эсэх, шинжээчийн дүгнэлт бодитой гарах боломжтой эсэх нь эргэлзээтэй байна.

Төслийн 67 дугаар зүйлийн 67.1-д хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үрчлэлийн зөвлөл гэснийг орон тооны байхаар хуулийн төсөлд тусгаснаар практикт хэрэгжих ба энэ нь хуулийн хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх, тухайн асуудлын ач холбогдлыг үнэлж буй явдал гэж үзэж байна. Мөн хүүхэд үрчлэлтийн асуудлыг шүүх шийдэх нь илүү нухацтай, хүүхдийн эрх ашиг хөндөгдөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой боловч практикт хэрэгжүүлэхийн тулд шүүгчийн орон тоог нэмэх шаардлагатай байна.

Харилцан уялдаа. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд аргачлалд тусгагдсан асуултанд хариулах замаар хуулийн төслийн үр нөлөөг үнэллээ. Хуулийн төслийн холбогдох зохицуулалтыг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх шаардлагатай байна. Тухайлбал, хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт тусгасан гэрлэлтийн гэрээний зохицуулалтыг Иргэний хуулийн 132 дугаар зүйлтэй нийцүүлэх шаардлагатай. Мөн хуулийн төслийн зүйл, заалт хоорондын уялдаа холбоо, нийцлийг сайжруулах, нэр томъёог жигдлэх шаардлагатай. Энэ хүрээнд зөвлөмжид заасан агуулгын болон техникийн хувьд сайжруулах саналыг анхаарах шаардлагатай байна.

Зөвлөмж

Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэсэн найруулгын төсөл нь гэр бүлийн харилцаанд хүүхдийн эрх, ашиг сонирхол, гэрлэгчдийн эд хөрөнгийн эрх ашиг сонирхлыг хамгаалах зохицуулалтыг улам боловсронгуй болгох буюу шинээр үүсч буюу харилцааг хуульд оруулж үүнээс үүсэх маргаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор боловсруулагдсан байна. Хуулийн төслийн үр нөлөөг “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлэхэд Гэр бүлийн тухай хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

Харин үр нөлөөг тооцох ажиллагааны явцад гарсан дараах асуудлуудыг өөрчлөх, дахин анхаарах шаардлагатай байна гэсэн зөвлөмжийг хууль санаачлагчид өгч байна. Үүнд:

1. Хуулийн төслийн 22, 23 дугаар зүйлүүд Иргэнийн хуулийн заалтуудтай зөрчилдөж байх тул Гэрлэлтийн гэрээгээр зөвхөн эд хөрөнгийн харилцааг зохицуулахаар өөрчлөх, Иргэний хуулийн 125 дугаар зүйлийн 125.2-т заасан гэрээ хуулийн төслийн 23 дугаар зүйлийн 23.1-т заасан гэрээ мөн эсэхийг тодорхойлж Иргэний хуулийн холбоосыг тухайн хэсэгт заах;
2. Хуулийн төслийн 5.3-т заасан садан төрлийн лавлагаа авч болно гэснийг садан төрлийн лавлагаа авна гэж үүрэгжүүлэн өөрчлөх;
3. Хуулийн төслийн 49 дүгээр зүйлийн 49.1-д заасан тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг төлөгчийн орлоготой уялдуулж шүүх тогтооно гэснийг шүүхээс орлого тогтоох ажиллагаа явуулахад хүндрэл бэрхшээл үүсэх тул энэ хэсгийг дахин хянан шалгах;
4. Монгол улсын хэмжээнд генетик генелогийн суурь судалгаа хийсний дараа гэрлэхийг хүсэгчид гэрлэлтээ батлуулахаас өмнө хоорондоо садан, төрлийн холбоотой эсэхээ мэдэх зорилгоор ДНХ (Дезоксирибонуклейн хүчил)-ийн шинжилгээнд хамрагдах талаар хуулийн төсөлд тусгах;
5. Эцэг, эх байх эрхээ хасуулсан, хязгаарлуулсан хүний зан үйлд нөлөөлөх сургалтыг ГБХЗХГ, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтарч зохион байгуулах талаар хуулийн төсөлд тусгах;
6. Хүүхдийг үрчлүүлэх эсэх асуудлаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Үрчлэлийн зөвлөл гэснийг орон тооны байхаар хуулийн төсөлд тусгах;
7. Хүүхэд үрчлэлтийн асуудлыг шүүх шийдвэрлэх, мөн бусад нэмэлт үүргүүд шүүхийн байгууллагад үүссэн нь шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх тул шүүхэд үүсэх ачааллыг тооцсоны үндсэн дээр шүүхэд шилжүүлэх, нэмэх үүргийг хуулийн төсөлд тусгах;
8. Хуулийн төслийн Гуравдугаар бүлэгт заасан гэрлэлтийн гэрээний зохицуулалтыг Иргэний хуулийн 132 дугаар зүйлтэй нийцүүлэх;
9. Хуулийн төслийн Гуравдугаар бүлгийн гарчгийг “Гэрлэлтийн гэрээ, түүнийг байгуулах” гэж өөрчлөх. Мөн хуулийн төслийн 23 дугаар зүйлийн гарчгийг “Гэрлэлтийн гэрээний хэлбэр” гэснийг “Гэрлэлтийн гэрээний зүйл, агуулга” гэж өөрчлөх;
10. Хуулийн төслийн 23.1-д “Гэрлэгчид гэрлэлтээ бүртгүүлэх” гэрлэгчид гэснийг давхардсан тул хасах;
11. Хуулийн төслийн 34 дүгээр зүйлийн 34.4, 34.5, 34.6 дахь хэсэгт заасан “Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх тухай гэрээ” гэснийг “Энэ хуулийн 34.3-т заасан гэрээ” гэж өөрчлөх. Мөн хуулийн дээрх заалтуудад гэрээний нэрийг “Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх тухай гэрээ” эсхүл “хэрэгжүүлэх гэрээ” гэж өөр өөр нэр томъёогоор илэрхийлснийг жигдлэх. 34 дүгээр зүйлийн гарчигт “эрх, үүрэг” гэсний араас “түүнийг хэрэгжүүлэх гэрээ” гэж нэмэх;
12. Хуулийн төслийн 90 дүгээр зүйлд буюу гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт дараах зохицуулалтыг нэмж тусгах;

Үүнд:

- гэрлэлт цуцлахад хүүхдийн асрамж тогтоох асуудлаар шүүгчийн захирамжийн дагуу шинжээчээр ажиллах, энэ чиглэлээр шүүхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;”
- Гэр бүлийг эвлэрүүлэх, хүүхдийг эцэг, эхийн аль нэгний асрамжид үлдээх асуудлаар шүүхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, дүгнэлт гаргах чиг үүргийг гүйцэтгэх төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх,
- Гэр бүлийг эвлэрүүлэх, хүүхдийг эцэг, эхийн аль нэгний асрамжид үлдээх асуудлаар шүүхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, дүгнэлт гаргах аргачлал, төлбөрийн хэмжээ, стандартыг батлах, хэрэгжилтийг хангах,

13. Дагалдах хуулийн төслийг дараах хэлбэрээр өөрчлөх; Үүнд:

- Дагалдах хуулийн төсөлд “132.4. Харин гэрлэгчид эвлэрэх боломжгүй буюу гэрлэгчдийн хэн нэгний байнгын хүчирхийлэл дарамтаас болж” гэсний “байнгын” гэдгийг хасах.
- Хуулийн төслийн 32.4.2-т “*Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 32.4-т зааснаас гадна өмгөөлөгч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулж, гэрлэгчдэд зөвлөгөө өгөх*” гэснийг “энэ хуулийн 32.4-т зааснаас гадна” гэж өөрчлөх.
- Түүнчлэн “Энэ хуулийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэснийг “Гэр бүлийн тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж өөрчлөх.
- Дагалдах хуулийн “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” гэснийг “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” гэж өөрчлөх.

---oOo---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль /1992/;
2. Хууль тогтоомжийн тухай хууль /2015 он/;
3. Гэр бүлийн тухай хууль;
4. Донорын тухай хууль;
5. Иргэний хууль;
6. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”;
7. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”;
8. Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоол;
9. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”;
10. Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/500 дугаар захирамж,
11. Гэр бүлийн эрх зүй дэх гэрээ бакалаврын ажил, Б. Уянга, 2017
12. Хууль ёсоор өв залгамжлах эрх зүйн харилцаан дахь дагавар хүүхдийн эрхийн хамгаалалт магистрын ажил, А. Тайван, 2020
13. Монгол Улсын харьяат хүүхдийг гадаадын иргэнд үрчлэх гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын асуудал бакалаврын ажил, 2018
14. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийг мөрдөн шалгахад прокурорын хяналтыг боловсронгуй болгох нь, өгүүлэл, Ж. Батмөнх, 2020
15. Хүүдийн асуудал хариуцах хорооны дүрмийг боловсронгуй болгох, хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах, ХЗҮХ, 2009
16. Гэр бүлийн хүчирхийлэл дэх гэмт хэрэг, зөрчлийн давхардал (Бодлогын судалгааны тайлан), Ж. Батмөнх, Э. Цэлмэг, 2022
17. Гэр бүлийн дундын эд хөрөнгийн эрх зүйн зохицуулалт докторын диссертаци, О. Отгонтуяа, 2022
18. Гэр бүлийн хүчирхийлэл: өнөөгийн байдал, О. Отгонтуяа, 2019
19. Хүүхдийн эд хөрөнгийн эрх, О. Отгонтуяа, 2021
20. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй практик орчин тулгамдсан асуудал, Д. Батням, 2022

